

# ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ДЭХ ГАДААД СЕКТОРЫН ОРОЛЦОО

## ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар Монголын эдийн засаг дахь гадаад секторын оролцоо<sup>1</sup> ямар байдалтай байгааг гарган судалсан. Ийнхүү судлахдаа эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ болон салбаруудад гадны хөрөнгө оруулалтаар байгуулагдаж буй компаниудын үйл ажиллагааны идэвхижил нь салбаруудын өсөлтөд хэрхэн нөлөөлж байгааг танилцуулж эмпирик байдлаар шалгасан.<sup>2</sup> Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО), ДНБ-ний хоорондын Гранжер шалтгаан нь ямар чиглэлтэй байгаа, урт хугацаанд ГШХО-ын өсөлт нь эдийн засгийн өсөлтөд хэр нөлөөтэй байдлыг тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд (Азербайжан, Гүрж, Казахстан, Молдав, Тажикстан, Армен) болон Монгол улс гэсэн 7 орны 1994-2004 оны тоон өгөгдлийг ашиглан эконометрик аргаар судалсан болно.

## I. ТАНИЛЦУУЛГА

Хөгжиж буй орнуудын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлт улмаар эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой гэж үздэг. Энэ утгаараа ч манай оронд сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалт өсөн, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нэмэгдэн эдийн засгийн тодорхой салбаруудад тэргүүлэх байр суурь эзлэн ажиллаж байна. Иймд эдийн засаг дахь гадаад секторын оролцоо ямар байгаа, гадаадын хөрөнгө оруулалтын өгөөж, үр ашиг нь эдийн засгийн өсөлт, хөгжилд үзүүлж буй нөлөөг тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм.

Гадаад секторын эдийн засагт үзүүлэх нөлөө, оролцоог тус сектор эдийн засгийн өсөлтийн хэдэн хувийг бий болгож байна вэ?, эдийн засаг дахь гадаад секторын үр нөлөө ямар байна вэ?, улсын төсвийн татварын орлогын хэдэн хувийг гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд бүрдүүлж байна, гадаад секторын дотоод эдийн засаг, нийгмийн хөгжилд тооны өсөлтөөс гадна, чанарын хувьд ямар эерэг дам нөлөөллүүдийг бий болгож байгаа зэрэг тулгамдсан асуудлуудад хариу өгөх нь сонирхолтой хэдий ч манай орны хувьд тоон мэдээлэл хомс, эдгээрийг бүгдийг нь тооцон гаргахад хангалттай хэмжээний тоон мэдээлэл үгүй тул тооцон гаргах боломж байсангүй. Тухайн судалгаагаар Монголын эдийн засаг дахь гадаад секторын оролцооны байдлыг тоон мэдээллийн боломжийн хүрээнд танилцуулан, ГШХО болон ДНБ-ний хоорондын чиглэл, хамаарлыг ижил шилжилтийн эдийн засагтай орнуудаас манай оронтой нэг хүнд ногдох ДНБ болон ГШХО, ДНБ-ний харьцаа ойролцоо орнуудыг сонгон Panel өгөгдөл үүсгэн ашиглаж эконометрик шинжилгээгээр илрүүлэн судлахыг зорьсон болно.

Судалгааны 2 дугаар хэсэгт "гадаадын хөрөнгө оруулалт"-ын тухай хуульд гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой нэр томъёог юу гэж авч үзсэн байдлыг дурьдан, онолын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлж болох онолын хандлага, түүнийг шалгах эконометрик загварыг авч үзлээ. Судалгааны 3 дугаар хэсэгт эмпирик байдлыг авч үзсэн бөгөөд гадаад сектор (гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд)-ыг бий болгох санхүүгийн эх үүсвэр гэдэг утгаар нь эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалтын хэсгийг голлон авч үзэн салбарууд дахь гадаад секторын эх

<sup>1</sup> Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын тухайн салбартаа эзлэх байр суурь, эдийн засгийн өсөлт хөгжилд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох байдлаар эдийн засаг дахь гадаад секторын оролцоог судална.

<sup>2</sup> Энэ хүрээнд судлахдаа тухайн гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын байгаль орчны бохирдол, зүй бус үйлдэл, татварын хөнгөлөлт эдлэх хугацаандаа үйл ажиллагаа эрхлээд нөхөн сэргээлт үзүүлэхгүй байх, компани татан буугдах, хууль бус үйлдэл гаргах зэрэг дам нийгэм, байгаль орчин, ёсзүйн чиглэлийн нөхцлүүдийг авч үзээгүй бөгөөд салбаруудын зөвхөн эдийн засгийн үзүүлэлтүүдийг авч үзсэн.

үүсвэр, компаниудын тоо, бүс нутгийн тархалтыг гарган судалж, салбаруудад ийнхүү гадаадын хөрөнгө оруулалт, компаниуд орж ирснээр тухайн салбарын өсөлтөөр дамжин эдийн засгийн өсөлтөд нөлөөтэй байгаа эсэхийг холбон судалсан. Мөн ГШХО, ДНБ-ний хоорондын Гранжер шалтгаан, урт хугацааны хамаарлыг panel өгөгдөл ашиглан экометрик үнэлгээ хийн шалгасан. Харин 4 дүгээр хэсэгт судалгааны үр дүн, дүгнэлтүүдийг нэгтгэн дурьдсан болно.

## **II. ОНОЛЫН ХЭСЭГ**

### **2.1 Гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн тухай ойлголт**

Гадаадын хөрөнгө оруулалт болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль"-д 1993 оны 5 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан "гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хуульд дараах байдлаар заажээ. Үүнд:

"Гадаадын хөрөнгө оруулалт- Монгол улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ."

"Гадаадын хөрөнгө оруулагч- Монгол улсад хөрөнгө оруулалт хийж буй гадаадын хуулийн этгээд, хувь хүн (Монгол улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаадад байнга оршин суудаг Монгол улсын иргэн)-ийг хэлнэ."

"Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж- Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, дүрмийн сангийн 20-иас доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн аж ахуйн нэгжийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэнэ."

"Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)- Аливаа нэг улсын хөрөнгө оруулагч өөр улсад бизнесээ өргөжүүлэх замаар аж ахуйн нэгжийн хувьцааг эзэмших бөгөөд нийт хувьцааны эзэмших хэмжээ нь хөрөнгө оруулагчид аж ахуйн нэгжийн удирдлагын хяналтыг өгч байх үед гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдлээ гэж ойлгодог".<sup>3</sup> Дээрхээс үзэхэд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь гадаадын хөрөнгө оруулалт орж ирэн өргөжих болон гадаадын хөрөнгө оруулалтаар шинээр байгуулагдаж үйл ажиллагаа явуулах гэсэн 2 байдалтай байж болох хэдий ч эцэстээ гадаадын хөрөнгө оруулалт (дээр тодорхойлсны дагуу) орж ирснээр л гадаад сектор (гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж)-ыг бий болгоно.

### **2.2 ГШХО болон эдийн засгийн өсөлт**

ГШХО-тай компаниуд олноор байгуулагдаж, ГШХО нэмэгдэх нь шууд болон дам нөлөөгөөр эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлдэг гэж макро эдийн засгийн хувьд үздэг. Borensztein болон бусад (1998), Carkovic, Levine (2002), Alfaro ба бусад (2001) нар cross-section эмпирик судалгааны ажлуудаар ГШХО нь эдийн засагт экзоген байдлаар эерэг нөлөөтэй болохыг тодорхойлсон байдаг. Эдгээр судалгаануудад ГШХО бодит эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхэд тухайн орны санхүүгийн зах зээлийн хөгжил болон боловсролын түвшин чухал үүрэгтэй гэж үзсэн байдаг.

Тухайн хандлагуудыг харуулсан суурь судалгаануудаас иш татан авч үзвэл, Borensztein болон бусад (1998) нарын судалгаанд аж үйлдвэржсэн орнуудаас 69 хөгжиж буй орон (ХБО)-д оруулсан ГШХО-ын өгөгдлийг ашиглан судалж ГШХО нь технологи болон өндөр өсөлтийн шилжилтийг бий болгосноор тухайн ХБО-ны хувьд хүмүүн капиталыг

<sup>3</sup> Н.Батсайхан (2003) "Гадаадын шууд хөрөнгө оруулалт"

нэмэгдүүлэх<sup>4</sup> чухал дамжлага болж байгааг тодорхойлсон. De Mello (1999) эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын гишүүн болон гишүүн бус Азийн орнуудын хувьд судлан ГШХО нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөтэйг тодорхойлсон. Reisen болон Soto (2001) нар ГШХО болон нэг талт хөрөнгийн урсгал, ДНБ-ний өсөлтийн хооронд эерэг хамааралтай болохыг үзүүлсэн байдаг.

Эдгээрээс авч үзвэл ГШХО нь эдийн засгийн өсөлт, хөгжилд эерэг нөлөөтэй болох нь олон судалгааны ажлуудаар нотлогдсон байна. Онолын хувьд ГШХО нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөтэй байж болохыг  $FDI \uparrow \rightarrow GDP \uparrow$  холбоогоор гаргахын тулд дараах энгийн дотоод өсөлтийн загвараар тайлбарлан авч үзье. Үйлдвэрлэлийн функц нь капитал (K) болон хүмүүн капитал (H), хөдөлмөр (L)-өөс хамаарах бөгөөд технологи (A)-ийн дэвшил эдгээр хүчин зүйлсийг чанаржуулж, сайжруулдаг гэж таамаглая:

$$Y = F(AK ; AH ; AL) \quad (1)$$

Онолын хувьд (1) хэлбэрийн үйлдвэрийн функцийг хөдөлмөр хэмнэсэн технологитой, хүмүүн капиталтай, технологийн дэвшлээр капитал, хүмүүн капитал нь сайжирдаг үйлдвэрлэлийн функц гэж үзнэ. Ингэж үзсэнээр нийт эдийн засгийн өсөлт нь (2) хэлбэртэйгээр буюу хүчин зүйлсийн өсөлт болон технологийн дэвшлийн өсөлтийг тэдгээрийн мэдрэмжээр (Кобб-Дугласын үйлдвэрлэлийн функцын хувьд) харгалзан үржүүлсэн нийлбэрээр тодорхойлогдоно.

$$\frac{Y'}{Y} = \alpha \left( \frac{K'}{K} + \frac{A'}{A} \right) + \beta \left( \frac{H'}{H} + \frac{A'}{A} \right) + \gamma \left( \frac{L'}{L} + \frac{A'}{A} \right) = \alpha \frac{K'}{K} + \beta \frac{H'}{H} + \gamma \frac{L'}{L} + (\alpha + \beta + \gamma) \frac{A'}{A} \quad (2)$$

Энд  $\alpha$  – Капиталын мэдрэмж,  $\beta$  - Хүмүүн капиталын мэдрэмж,  $\gamma$  - Хөдөлмөрийн мэдрэмж,  $(\alpha + \beta + \gamma)$  - Технологийн мэдрэмж

ГШХО өсөх нь технологийн дэвшлийг бий болгох, капиталжилтыг сайжруулах, хүмүүн капиталыг нэмэгдүүлэх, технологийн дэвшлээр хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэх бөгөөд энэ хэрээр эдийн засгийн өсөлт, хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг.<sup>5</sup> Үүнийг схемээр харуулбал:  $FDI \uparrow \Rightarrow A \uparrow, (AK) \uparrow, (AH) \uparrow, (AL) \uparrow \Rightarrow Y \uparrow$  буюу  $FDI \uparrow \Rightarrow Y \uparrow$  байна. Иймд онолын хувьд ГШХО орж ирэх нь эдийн засгийн өсөлтөд эерэг шууд нөлөөтэй байж болох бөгөөд харин эдийн засгийн хөгжилд орчин үеийн шинэ техник, технологи, хүмүүсийн ерөнхий мэдээлэл мэдлэг чадвар дээшлэх, ажлын байр бий болох (өрхийн орлого өсөх), дэд бүтэц, орчин сайжрах, татварын орлого өсөх зэрэг хөгжлийн үзүүлэлтүүдээр дамжин дам нөлөөг үзүүлдэг.

Мөн үүний эсрэгээр буюу ГШХО орж ирнээр эдийн засгийн өсөлт хурдсахаас гадна эдийн засгийн өсөлттэй байх нь гадаадын хөрөнгө оруулалтыг эргээд далладаг байж болно. Өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлт сайтай байгаа, санхүүгийн зах зээл нь тогтвортой байгаа оронд гадаадын хөрөнгө оруулагчид илүү үр өгөөжтэй, өсөж буй салбарт илүүтэй хөрөнгө оруулах, ГШХО-тай компани байгуулах хандлага байдаг. Энэ тохиолдолд  $GDP \uparrow \rightarrow FDI \uparrow$  холбоог мөн шалгах байдлаар судлах ёстой болно.

### 2.3 ГШХО болон эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарлыг шалгах эконометрик загвар

<sup>4</sup> Likewise, Xu (2000) нар АНУ-ын ОУ-ын үйлдвэрлэлийн компаниудын тоон мэдээлэл ашиглан технологийн шилжилтээс бий болох өгөөж нь хүмүүн капиталыг нэмэгдүүлж байгааг тодорхойлон гаргасан.

<sup>5</sup> Ийнхүү ГШХО орж ирэх нь технологийн дэвшил, мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх замаар АК, АН-ыг өсгөхөөс гадна, К,Н-үүд нь хөрөнгө оруулалт орж ирэхэд хэмжээний хувьд бодитоор бас өсөн мөн ажлын байр нэмэгдэх тул АК,АН,AL нь илүү хурдтай өсч эдгээрийн өсөлт нь эдийн засгийн өсөлтөд үндсэн байр суурь эзэлдэг.

Энэ хэсэгт гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) болон ДНБ-ний хоорондын Гранжер шалтгааны хамаарлыг шинжлэх эконометрик загварыг авч үзье. 2.2 хэсэгт онолын хувьд ГШХО болон ДНБ-ний хооронд хамаарал байж болох бөгөөд эдгээр нь харилцан бие биеэндээ нөлөө үзүүлж болох талаар дурьдсан. Иймд ГШХО-ын өсөлт нь ДНБ-ний өсөлтийн шалтгаан болж байна уу?, ДНБ-ний өсөлт нь ГШХО-ыг даллах шалтгаан болж байна уу? гэдэг асуултын хариултыг олоход тус загвар туслах юм.

Ийнхүү судлахдаа ДНБ-ний логарифм ( $\log(\text{GDP})$ ) болон ГШХО-ын ДНБ-нд эзлэх хувь ( $\text{FDI}/\text{GDP}$ ) үзүүлэлтүүдийн хувьд 2 хувьсагчийн вектор авторегрессив (Bi-Variate Vector Autoregressive-VAR) загварыг ашиглалаа. Тоон өгөдлийн хувьд ҮСГ-ын ГШХО-ын тоо, Европын сэргэн босголт, хөгжлийн банкны Transition Report 2002, 2004 болон World Investment Report 2005-аас 7 орны 11 жилийн (1994-2004) мэдээллээр байгуулсан panel өгөгдөл ашигласан. Дараах хялбар гэмдэглэгээ хийе. Үүнд:

$$x_{it} = [\log(\text{GDP}_{it}), \text{FDI}_{it} / \text{GDP}_{it}]',$$

энд  $i$  - Орнуудын индекс ( $i=1, \dots, N$ ),  $t$ - хугацааны индекс ( $t=1, \dots, T$ ).  $x_{it}$  үзүүлэлтүүдийн хувьд VAR загварыг бичвэл:<sup>6</sup>

$$x_{it} = A_{1i} x_{it-1} + A_{2i} x_{it-2} + \mu_i + \delta_i t + \lambda_i + \varepsilon_{it} \quad (1)$$

энд  $A_{ji}$  - ( $2 \times 2$ ) хэмжээтэй орнуудын төлөв байдлыг илэрхийлсэн параметрын матриц,  $\mu_i$  болон  $\delta_i$  -ууд нь ( $2 \times 1$ ) хэмжээтэй улс бүрийн онцлогийг илэрхийлсэн сул гишүүн болон тренд параметрууд,  $\lambda_i$  - ( $2 \times 1$ ) хэмжээтэй, тэг дундажтай, хугацааны турш өөрчлөгдөх нөлөөлөл, орнуудын хувьд ижилхэн гэж таамагласан,  $\varepsilon_{it}$  - ( $2 \times 1$ ) хэмжээтэй алдааны матриц, үүнийг  $iid(0, \Omega_i)$ , мөн ковариацийн матриц нь эерэг тодорхойлогдоно гэж таамагласан. Тухайн загварт ашиглаж буй тоон өгөгдөл нь panel тул тухайн тоон мэдээллийн шинж чанараас үүдэн алдааг  $u_{it} = \mu_i + \delta_i t + \lambda_i + \varepsilon_{it}$  гэж үзсэн.  $\mu_i$  нь тухайн орны хувьд хугацаанаас шалтгаалахгүй өөрчлөгддөг хүчин зүйлсийг илэрхийлэх параметр, харин  $\delta_i$  нь тухайн орны онцлогоос хамааран цаг хугацааны хувьд өөрчлөгдөж буй нөлөөллийг илэрхийлнэ.  $\lambda_i$  нь улс орнуудын онцлогоос шалтгаалахгүйгээр цаг хугацааны хувьд өөрчлөгдөх өөрчлөлтийн параметр, энд улс орнуудын хувьд  $\delta_i$  нь тогтмол байх бол түүний нөлөөг  $\lambda_i$  давхар агуулна. Харин  $\varepsilon_{it}$  нь тухайн орны онцлог болон хугацаанаас зэрэг шалтгаалж байдаг хүчин зүйлсийг агуулна. ГШХО нь ДНБ-ний Гранжер шалтгаан болохгүй гэсэн таамаглал нь дараах байдлаар тодорхойлогдоно:

$$H_0(\text{FDI} \not\rightarrow \text{GDP}): a_{12(ji)} = 0, \quad j=1,2 \quad (2)$$

энд  $a_{12(ji)} = 0$  нь  $A_{ji}$  матрицын (1,2) элементүүд. Хэрвээ тухайн таамаглал няцаагдвал ГШХО нь ДНБ-ний Гранжер шалтгаан болно гэж үзнэ. Эсрэг таамаглал буюу ДНБ нь ГШХО-ын Гранжер шалтгаан болохгүй гэсэн таамаглал нь:

$$H_0(\text{GDP} \not\rightarrow \text{FDI}): a_{21(ji)} = 0, \quad j=1,2 \quad (3)$$

<sup>6</sup> Эмпирик шинжилгээгээр статистик шалгуурууд болон алдааны автокорреляцийн хувьд бусад лагаас 2-р эрэмбийн VAR загвар нь харьцангуй сайн үнэлгээ харуулсан. Иймд тухайн загвартаа VAR(2) загварыг сонгон ашигласан.

ГШХО болон эдийн засгийн өсөлт, ГШХО болон ДНБ-ний хоорондын Гранжер шалтгааныг судалсан судалгааны ажлууд олон байдаг. Эдгээрээс товч авч үзвэл Zhang (2001) 11 орны хувьд улс улсаар нь time series өгөгдөл ашиглан алдааг залруулах загвар (error correction model) ашиглан ГШХО болон ДНБ-ний өсөлтийн хоорондын урт хугацааны Гранжер шалтгааныг шалгасан. Үр дүн нь 6 орны хувьд логарифм ГШХО болон өсөлтийн хооронд коинтегрэши хамаарал байгаагүй бөгөөд зөвхөн нэг орны хувьд ГШХО нь өсөлтийн Гранжер шалтгаан болж байгааг харуулсан. Харин Nair-Reichert болон Weinhold (2001) нар 24 орны 1971-1995 оны өгөгдлөөр panel үүсгэн шалтгааныг шалгасан. Үр дүнд нь ГШХО нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэй болохыг тодорхойлсон байдаг.

Хэрвээ ГШХО нь ДНБ-ний Гранжер шалтгаан болдог бол энэ нь мөн ДНБ-ний өсөлтийн шалтгаан болно гэж үзэн VAR загварыг error-correction хэлбэрт оруулан дахин бичвэл:

$$\Delta x_{it} = \Gamma_{1i} \Delta x_{it-1} + \Pi_i x_{it-1} + \mu_i + \delta_i t + \lambda_i + \varepsilon_{it} \quad (4)$$

энд  $\Pi_i = (A_{1i} + A_{2i} - I)$ ,  $\Gamma_{1i} = -A_{2i}$  орлуулга хийгдсэн болно.<sup>7</sup>

Энэ томъёололд хамаарах хувьсагчид нь log(GDP)-ийн өөрчлөлт (эдийн засгийн өсөлт) болон ГШХО-ын өөрчлөлт байна. Error-correction хэлбэрийн хувьд Гранжер шалтгааны таамаглал нь :

$$\begin{aligned} H_0(FDI \not\rightarrow GDP) : \gamma_{12} = 0 \quad \text{and} \quad \pi_{12} = 0, \quad j=1,2 \\ H_0(GDP \not\rightarrow FDI) : \gamma_{21} = 0 \quad \text{and} \quad \pi_{21} = 0, \quad j=1,2 \end{aligned} \quad (5)$$

Зарим судлаачид (Zhang (2001) болон Vasu ба бусад (2003)) Гранжер шалтгаан байхгүй гэсэн урт болон богино хугацааны 2 дэд таамаглалыг авч судалсан байдаг. Богино хугацааны Гранжер шалтгаан болохгүй гэсэн таамаглал нь  $\Gamma$  матрицын эерэг диагоналийн элементүүд ( $\gamma_{12} = 0$ ,  $\gamma_{21} = 0$ ) тэгтэй тэнцүү бол урт хугацааны Гранжер шалтгаан болохгүй гэсэн таамаглал нь  $\Pi$  матрицын эерэг диагоналийн элементүүд ( $\pi_{12} = 0$ ,  $\pi_{21} = 0$ ) нь тэгтэй тэнцүү байх ёстой болно.

Манай судалгааны хувьд Гранжер шалтгааны сонгодог хэлбэр болох (5) хэлбэрийн тэг таамаглалыг ашиглана, нөлөөтэй эсэхийн (neutrality) таамаглалд  $\Pi$  матрицын эерэг диагоналийн элементүүд ( $\pi_{12} = 0$ ,  $\pi_{21} = 0$ ) нь тэгтэй тэнцүү байгаа эсэхийг шалгасан болно. Нөлөөтэй эсэхийн (neutrality) таамаглалыг шалгах нь сонирхолтой, учир нь урт хугацаанд ГШХО өсөөд байх нь эдийн засгийн өсөлтөд нөлөөтэй эсэхийг мэдэх ач холбогдолтой юм. Анхны (1) хамаарлыг moving average хэлбэрт шилжүүлж загварыг дахин их Т түүврийн хувьд бичвэл:

$$x_{it} = C_i (\mu_i + \delta_i t) + C_i (L) (\lambda_i + \varepsilon_{it}) + (\text{initial condition}) \quad (6)$$

Энэ загварын хувьд урт хугацаанд ГШХО-ын ДНБ-нд үзүүлэх нөлөө нь  $C_{12(i)}$ -ээр илэрхийлэгдэнэ. Энэ нөлөөллийг урт хугацааны нөлөөлийн параметрийг ашиглан тооцох бөгөөд эдийн засгийн онолын хувьд урт хугацааны хамаарал нь тухайн үзүүлэлт тогтвортой төлөв дээрээ байгаа үед буюу тэдгээрийн өсөлт нь тэг болсон үед гарч ирдэг. Иймд (4) хамаарлын өсөлтүүд буюу өөрчлөлт нь тэг болох бөгөөд үлдэж буй хэсгийг нь moving average хэлбэрт шилжүүлж харгалзах коэффициентийг (6)-тай тэнцүүлэх байдлаар

<sup>7</sup> Тэгшитгэл (1)-ээс лагтай үзүүлэлтүүдийг хойноос нь урагш нь ялгавар авах байдлаар устгах замаар (4)-г гаргасан болно.

урт хугацааны хамаарлын коэффициентийн матрицыг тодорхойлбол (С болон П матрицын хамаарал нь):

$$C_i = -\Pi_i^{-1} = \frac{1}{|\Pi_i|} \begin{bmatrix} -\pi_{22(i)} & \pi_{12(i)} \\ \pi_{21(i)} & -\pi_{11(i)} \end{bmatrix} \quad (7)$$

Энэ хамаарлаас neutrality байдал нь: хэрвээ  $\pi_{12(i)} = 0$  буюу  $c_{12(i)} = 0$  байвал урт хугацаанд ГШХО нь ДНБ-нд огт нөлөөгүй байна.<sup>8</sup>

Тухайн загварыг ашиглан эконометрик үнэлгээг хийснээр ГШХО болон ДНБ хоорондын чиглэлийг тодорхойлох (ГШХО-ын өсөлт нь ДНБ-ний өсөлтийн шалтгаан болж байна уу, эсвэл ДНБ-ний өсөлт нь ГШХО-ыг даллаж байна уу гэсэн асуултын хариултыг олох), мөн урт хугацаанд ГШХО-ын 1 хувийн өсөлт нь ДНБ-ний хэдэн хувийн өсөлтийг бий болгож байгааг тодорхойлох боломжийг бий болгох юм.

### III. ЭМПИРИК СУДАЛГААНЫ ХЭСЭГ

#### 3.1 Эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалт

##### 3.1.1 Монгол улсын нийт хөрөнгө оруулалт, гадаад хөрөнгө оруулалтын талаар

Сүүлийн жилүүдэд манай оронд орж ирж буй хөрөнгө оруулалт үүнээс гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалт ямар байдалтай байгааг авч үзье. Монгол улсын нийт хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн бүтэц, ДНБ-нд эзлэх хувийг<sup>9</sup> 1990-2004 оны байдлаар хүснэгт 1-д үзүүллээ. Энд нэг зүйлийг тодотгоход гадаадын нийт хөрөнгө оруулалт болон ГШХО-ын тоон мэдээлэлийг ҮСГ-аас авч ашигласан бөгөөд ҮСГ-т гарч буй тухайн тоо нь гадаадын хөрөнгө оруулалтын орж ирсэн гүйцэтгэлээрх дүн бус, харин гадны хөрөнгө оруулагчид "Гадаадын хөрөнгө оруулалтын газар"-аас компани байгуулах зөвшөөрөл авахдаа амалсан хөрөнгө оруулалтын дүн болно.

Хүснэгт 1-ээс харахад гадаадын хөрөнгө оруулалтын хувьд 1992 онд манай оронд эдийн засгийн бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, улсын үйлдвэрийн газрууд хувьчлагдан, хувьчлагдах нэрийдлээр хувьд шилжсэн үйлдвэрүүдийн дампуурал, гадаад орчны хувьд социалист харилцаатай байсан орнуудын хувьд мөн задарснаас хөрөнгө оруулалт орж ирэхгүй зогсонги байдалд хүрсэн. Мөн хэт өндөр инфляци, эдийн засгийн уналт зэрэг нь хөрөнгө оруулагчид орж ирж ирэхээс зүрхшээхэд хүргэж байсны дээр хөрөнгө оруулалтын өгөөж тухайн үед ямар байх эсэх талаар судалгаа, шинжилгээ хийгдээгүй, гадаадын хөрөнгө оруулалтын эрхзүйн акт бүрдээгүй, татварын орчин тодорхой бус, өндөр байсан зэргээс улбаатайгаар гадны хөрөнгө оруулагч нар орж ирээгүй, эдийн засгийн хувьд тогтворгүй байсан нь тухайн онд гадны хөрөнгө оруулалт сүүлийн 15 жилд хамгийн доод түвшиндээ хүрсэн. Өөрөөр хэлбэл, 1990 онд гадаадын хөрөнгө оруулалт ДНБ-ний 11.8 % байсан бол 1991 онд 8.2% болж бууран 1992 оны байдлаар 1.7%-д хүрч буурсан.

Харин 1993 онд "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хууль батлагдсан, татварын орчны суурь тавигдсан, валютын ханшийг хөвдөг тогтолцоонд оруулсан болон гадаад улсуудтай эдийн засгийн харилцаа тогтоосноор эдийн засгийн хувьд шилжилтийн явцдаа байсан

<sup>8</sup>  $\pi_{21(i)} = 0$  үед ДНБ-ний ГШХО-д үзүүлэх нөлөөлөл нь neutrality байна.

<sup>9</sup> Хөрөнгө оруулалт болон ДНБ-ний харьцаа нь тухайн улс нийт үйлдвэрлэлийнхээ хэдэн хувьтай тэнцэх хөрөнгө оруулалт хийж байгааг илэрхийлнэ. Тухайн харьцаа өсөх нь шинэ үйлдвэр, шинэ технологи бий болж байна гэдэг утгаараа эдийн засгийн өсөлтийг хурдасгахад чухал ач холбогдолтой байдаг.

манай орны гадаад хөрөнгө оруулалт өмнөх онуудтай харьцуулахад огцом нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл өмнөх оныхоо гадаадын хөрөнгө оруулалтаас 30 дахин их хөрөнгө оруулалт орж ирж, гадаадын хөрөнгө оруулалтын ДНБ-нд эзлэх<sup>10</sup> хувь 12.3%-д хүрсэн хэдий ч энэ хөрөнгө оруулалтын дийлэх хэсэг нь компаниудын хувьцаа худалдаж авах, тоног төхөөрөмжийг шинэчлэх хөрөнгө, санхүүжилтийн шинж чанартай байсан (шинээр компани байгуулаагүй) бөгөөд энэ нь нийт хөрөнгө оруулалтын 0.7% нь л гадаадын шууд хөрөнгө оруулалт байснаар нотлогдож байна.

1993 онд нийт хөрөнгө оруулалт, ДНБ-ний харьцаа 23.2%, 1994 онд 19.2%, 1995 онд 16.6% байгаагаас гадаадын хөрөнгө оруулалт 1994 онд 9.3%, 1995 онд 7.8% буюу нийт хөрөнгө оруулалтын тэн хагасыг нь эзэлж байсан бол улс орны эдийн засагт бодитой хувь нэмэр үзүүлдэг гэж үздэг гадаадын шууд хөрөнгө оруулалт 1994 онд 1.5%, 1995 онд 3.3% болж өссөн байна. Эндээс харахад гадаадын шууд хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтадаа бага хувь эзэлж байсан хэдий ч нийт гадаадын хөрөнгө оруулалтад эзлэх хувь өсөх хандлага энэ үеэс ажиглагдаж эхэлсэн. Харин гадаадын хөрөнгө оруулалт дотроо шууд хөрөнгө оруулалтыг авч үзвэл 1996 онд 5.7%, 1997 онд 4.0%, 1998 онд 5.0%, 1999 онд 10.0% байсан бөгөөд 1993-1998 оны хооронд манай оронд хийгдсэн хөрөнгө оруулалтад гадаадын шууд хөрөнгө бага хувь эзэлж байсан бол 1999 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт гадаадын хөрөнгө оруулалтын 63.3%-г, нийт хөрөнгө оруулалтын 36.0%-г эзлэх болсон байна.

2000 оноос манай орны Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчдын чуулганыг салбарын шугамаар зохион байгуулах болсон, мөн Монголын эдийн засгийн байдал тогтворжин макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжран, улс төрийн байдал тогтворжин үүнтэй уялдан хууль, эрхзүй, татварын орчин тогтвортой байж, хөрөнгө оруулалтын үр өгөөж, нөөц, зах зээлийн байдлын судалгаанууд хийгдэх болж, өгөөж өндөртэй өсөж буй салбарт их хэмжээгээр хөрөнгө оруулалт орж ирэх болсноор хөрөнгө оруулалт хурдацтай өсөх болсон. ДНБ-нд эзлэх нийт хөрөнгө оруулалтын эзлэх хувь 2000-2004 онд 26.5-29.2%-тай байлаа. Эдгээрээс харахад 2000 оноос хойш нийт хөрөнгө оруулалтын хурдацтай өсөлт нь гадаадын хөрөнгө оруулалтын өсөлтөөр тайлбарлагдах бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт дотроо шууд хөрөнгө оруулалт нь 61.2-93.5%-ийг эзэлж байсан байна. Харин 2004 онд хөрөнгө оруулалт нэрлэсэн дүнгээрээ өссөн бөгөөд өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтын үр ашиг болон гадаад зах зээлийн таатай нөхцлөөс эдийн засаг 2004 онд 10.6% болж өссөнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт, ДНБ-ний харьцаа буурчээ.

---

<sup>10</sup> Гадаадын хөрөнгө оруулалт, ДНБ-ний харьцаа нь тухайн улсын нийт үйлдвэрлэлийн хэдэн хувьтай тэнцүү хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт манай оронд орж ирж байгааг илэрхийлнэ. тухайн харьцаа өсөх нь тухайн улсад гадаадын санхүүгийн эх үүсвэр их хэмжээгээр орж ирж байгааг илэрхийлэх бөгөөд ГШХО болон ДНБ-ний харьцаа өсөх нь эдийн засаг дахь гадаад секторын үйл ажиллагаа идэвхижил, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг давхар илэрхийлдэг.

**Хүснэгт 1. Монгол Улсын нийт хөрөнгө оруулалт, эх үүсвэрийн бүтэц, ДНБ-нд эзлэх хувь, 1990-2004 он\***

Он	Нийт хөрөнгө оруулалт	Эх үүсвэрээр, сая төгрөгөөр				ДНБ-нд эзлэх хувь (%)					
		Дотоодынх			Гадаадын хөрөнгө оруулалт	Нийт хөрөнгө оруулалт (%)	Дотоодынх (%)			Гадаадын хөрөнгө оруулалт (%)	Үүнээс гадаадын шууд хөрөнгө оруулалт (%)
		Улсын (дотоодынх)	Банкны зээл	Өөрийн хөрөнгө			Улсын (дотоодынх)	Банкны зээл	Өөрийн хөрөнгө		
1990	3 383.9	1 237.2	378.9	534.2	1 233.6	32.3	11.8	3.6	5.1	11.8	~
1991	3 928.7	970.1	267.8	1 132.2	1 558.6	20.8	5.1	1.4	6.0	8.2	~
1992	5 052.5	946.8	1 702.8	1 592.9	810.0	10.7	2.0	3.6	3.4	1.7	~
1993	45 200.0	5 000.0	4 400.0	11 800.0	24 000.0	23.2	2.6	2.3	6.1	12.3	0.7
1994	62 214.8	9 714.8	3 900.0	18 500.0	30 100.0	19.2	3.0	1.2	5.7	9.3	1.5
1995	91 527.0	13 200.0	9 000.0	26 617.0	42 710.0	16.6	2.4	1.6	4.8	7.8	3.3
1996	135 250.9	8 385.9	5 034.9	39 404.9	82 425.2	20.9	1.3	0.8	6.1	12.7	5.7
1997	180 300.0	19 000.0	8 000.0	40 000.0	113 300.0	21.7	2.3	1.0	4.8	13.6	4.0
1998	207 956.1	25 513.4	13 001.6	69 861.1	99 580.0	25.4	3.1	1.6	8.5	12.2	5.0
1999	257 342.3	24 484.8	11 005.2	75 663.2	146 189.1	27.8	2.6	1.2	8.2	15.8	10.0
2000	284 733.5	37 442.4	22 700.0	56 554.2	168 036.9	27.9	3.7	2.2	5.6	16.5	10.1
2001	309 530.4	40 870.3	11 018.4	55 736.2	200 905.5	27.7	3.7	1.0	5.0	18.0	12.1
2002	329 270.2	44 215.5	22 639.0	52 136.1	210 279.6	26.5	3.6	1.8	4.2	16.9	15.8
2003	426 660.3	55 028.7	29 822.6	67 679.5	274 129.5	29.2	3.8	2.0	4.6	18.8	15.8
2004	501 876.0	69 021.7	57 499.9	134 841.5	240 513.0	27.8	3.8	3.2	7.5	13.3	~

Эх үүсвэр: Үндэсний статистикийн газар

Энд: \*- Гадаадын болон ГШХО нь гадны хөрөнгө оруулагчид “Гадаадын хөрөнгө оруулалтын газар”-аас компани байгуулах зөвшөөрөл авахдаа амалсан (амлалтаарх) хөрөнгө оруулалтын дүнгээр байгаа болно.



Өөрийн орны ГШХО/ДНБ харьцааг шилжилтийн эдийн засагтай бусад орнуудтай харьцуулсан байдлыг хүснэгт 2-г харууллаа.

**Хүснэгт 2. Шилжилтийн эдийн засагтай орнуудын ГШХО/ДНБ (FDI/GDP)-ний харьцаа.**

	Армен	Гүрж	Узбекистан	Киргиз	Монгол*	Унгар	Польш
1994	1.2	0.6	1.3	3.1	1.5	2.7	0.6
1995	2.0	0.2	-0.3	5.7	3.3	9.9	1.0
1996	1.1	1.8	0.7	2.4	5.7	5.0	2.0
1997	3.2	6.7	1.5	4.7	4.0	3.8	2.2
1998	11.8	5.3	1.3	5.2	5.0	3.4	3.2
1999	6.7	2.1	1.5	3.0	10.0	3.5	4.1
2000	5.5	4.3	0.8	-0.4	10.1	2.3	5.1
2001	3.3	2.5	1.1	1.4	12.1	4.0	3.6
2002	4.7	3.9	0.8	1.6	15.8	4.3	2.0
2003	4.9	7.8	0.8	0.9	15.8	0.6	1.9
2004	5.8	10.3	2.0	5.7	12.1	3.6	2.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар, European Bank for Reconstruction and Development (EBRD), "Transition report 2002 and 2004"

\*-ҮСГ, тус тооцоонд ГШХО нь гадны хөрөнгө оруулагчид "Гадаадын хөрөнгө оруулалтын газар"-аас компани байгуулах зөвшөөрөл авахдаа амалсан хөрөнгө оруулалтын дүн болно.

Хүснэгт 2- оос харахад 1994-1998 оны хооронд манай орны ГШХО, ДНБ-ний харьцаа шилжилтийн эдийн засагтай бусад тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН)- ийн орнууд (Армен, Гүрж, Киргиз, Узбекистан), Төв Европ болон Балтын орнууд (Унгар, Польш) -ын түвшинтэй ойролцоо түвшинд буюу 1.5-5.0 хувь байсан бол 1999 онд манай орны гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом нэмэгдэж тус харьцаа 10 хувьд хүрч улмаар цааш өссөн нь шилжилтийн тухайн орнуудаас тухайн үзүүлэлтийн хувьд өндөр байна.

Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН)-ийн орнуудаас Узбекистан улсын ГШХО/ДНБ харьцаа хамгийн доогуур буюу 1.7-2.0 хувь байдаг бол 2000-2004 оны хооронд Армены ГШХО/ДНБ харьцаа 3.3-5.8 хувь буюу харьцангуй тогтвортой, Гүржийн хувьд 2000-2002 онуудад 2.5-4.3 хувь, 2003-2004 онуудад 7.8-10.3 хувь болтлоо өссөн, Киргизын хувьд 2000-2003 онуудад 0.9- 1.6 хувь байсан бол 2004 онд 5.7 хувь болтлоо өссөн байна. Эндээс үзэхэд сүүлийн жилүүдэд ТУХН-ийн орнууд болон манай оронд гадаадын шууд хөрөнгө оруулалт хурдацтай өссөн байна. Харин Төв Европ болон Балтын орнууд болох Унгарын хувьд тус харьцаа 1996-2001 онуудын хооронд харьцангуй тогтвортой 2.3-5.0 хувь, Польш улсын хувьд 2.0-5.1 хувь байсан байна.

Монголын ГШХО/ДНБ-ний харьцаа нь 1993-1995 онуудад 0.7-3.3 хувь, 1996-1998 оны онуудад 4.0-5.7 хувь байсан бол 1999-2004 оны хооронд 10.0-15.8 хувь болтлоо өссөн байна. Энэхүү үзүүлэлтийг бусад эдийн засгуудтай харьцуулж авч үзвэл: 1980-1990 оны үед дэлхийн хувьд тухайн харьцаа дундажаар 6.7 хувь, хөгжсөн эдийн засгийн хувьд 4.9 хувь, хөгжиж буй эдийн засгийн хувьд 12.6 хувь, хөгжиж буй орнуудын хувьд (Хятад гэх мэт) 13.5 хувь байсан бол 2000-2004 оны хооронд дундажаар дэлхийн хувьд тухайн харьцаа 22.3 хувь, хөгжсөн эдийн засгийн хувьд 18.7 хувь, хөгжиж буй эдийн засгийн хувьд 36.0 хувь, хөгжиж буй орнуудын хувьд (Хятад гэх мэт) 35.8 хувь байжээ.<sup>11</sup>

Манай улс хөгжиж буй эдийн засгийн ангилалд орохын хувьд дундаж түвшинтэй нь харьцуулж үзэхэд манай орны ГШХО/ДНБ-ний харьцаа маш доогуур түвшинд байна. Харин 2000-2004 оны хооронд тухайн харьцааг хөгжиж буй эдийн засгийг дотор нь задалж авч үзвэл Африкын Сахарын бүс нутагт 37.5 хувь, Хойд Америкт 48.8 хувь, Зүүн

<sup>11</sup> Эх сурвалж: UNCTAD, FDI database

хойд Азид 38.0 хувь, жижиг хөгжиж буй орнуудад 23.5 хувь байна. Эдгээртэй харьцуулахад манай орны ГШХО/ДНБ харьцаа хангалтгүй байна.

### **3.1.2 Нийт хөрөнгө оруулалтын бүтэц: Технологийн бүтэц, эх үүсвэрийн бүтэц**

Нийт хөрөнгө оруулалтыг бүтцээр нь авч үзсэн байдлыг технологийн бүтэц (Барилга угсралт, тоног төхөөрөмж, бусад) болон эх үүсвэрийн бүтцийг (дотоод эх үүсвэр: улсын, банкны зээл, өөрийн хөрөнгө болон гадаад хөрөнгө оруулалт) хавсралт 1-д нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувиар үзүүлсэн. 1993-2000 оны хооронд хөрөнгө оруулалтын бүтцэд өөрчлөлт орсон бөгөөд технологийн бүтцийн хувьд барилга угсралтын эзлэх хувь 62.8%-иас 25.4% болж буурч, тоног төхөөрөмжид оруулсан хөрөнгө оруулалтын эзлэх хувь 36.8%-иас 43.3% хүртлээ өссөн байна.

Эх үүсвэрийн хувьд улсын үйлдвэрийн газрууд хувьчлагдан эдийн засагт улсын секторын эзлэх хувь буурсантай холбоотой дотоод хөрөнгө оруулалтын нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь 15.6%-аас 13.1% болтлоо буурсан. Мөн банк санхүүгийн хямралын үе таарсантай холбоотой банкны зээлээр санхүүжсэн хөрөнгө оруулалтын эзлэх хувь 9.7%-иас 4.3% болтлоо буурч ирсний дээр хувийн компаниудын үйл ажиллагаа тогтворжиж идэвхижиж эхэлсэнтэй холбоотой өөрийн хөрөнгөөрх хөрөнгө оруулалтын хувь өсөх хандлага болж ирсэн. Ийнхүү дотоод эх үүсвэрийн эзлэх хувь буурахад гадаадын хөрөнгө оруулалтын өсөлт нөлөөлсөн бөгөөд нийт хөрөнгө оруулалтад гадаадын хөрөнгө оруулалтын эзлэх хувь 16.0%-иас 59.0% хувь хүртлээ өссөн нь нийт хөрөнгө оруулалтын өсөлтөд дийлэнх хувь эзэлж байна. Энэхүү гадаад хөрөнгө оруулалтад мөн үеэс эхлэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын эзлэх хувь өсөж эхэлсэн бөгөөд тухайн хугацаанд 5.7%-иас 63.3% болж өссөн байна.

2000 оноос хойш манай оронд хөрөнгө оруулалт улам илүү хурдацтай өсөж байгаа бөгөөд технологийн бүтцийн хувьд барилга угсралтад хийгдэж буй хөрөнгө оруулалтын эзлэх хувь 25.4%-иас 35.7% болтлоо өссөн бөгөөд энэ нь орон сууцны барилгын салбар сүүлийн жилүүдэд өсөж буйгаар тайлбарлагдах бол тоног төхөөрөмжийг эзлэх хувь 43.3%-иас 51.8% болтлоо өссөн бөгөөд хөрөнгө оруулалт эдгээр чиглэлд түлхүү хийгдэж байна. Харин эх үүсвэрийн хувьд нийт хөрөнгө оруулалтад гадаад хөрөнгө оруулалтын эзлэх хувь 59.0%-иас 64.3% хүртэл өссөн бөгөөд үүн дотроо шууд хөрөнгө оруулалт нь гадаадын хөрөнгө оруулалтыг тодорхойлон улмаар нийт хөрөнгө оруулалтын өсөлтийн дийлэнх хэсэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлтөөр тодорхойлогдож байна. 2004 онд гадаадын хөрөнгө оруулалтын дүн нэрлэсэн дүнгээрээ өссөн хэдий ч нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь буурсан нь өөрийн хөрөнгөөрх хөрөнгө оруулалт хурдацтай өсөн 26.9%-ийг эзлэх болсон болон банкны зээлээр санхүүжсэн хөрөнгө оруулалт тухайн онд 27.7 тэрбум төгрөгөөр өсөж нийт хөрөнгө оруулалтын 11.5%-ийг эзлэх болсонтой холбоотой юм.<sup>12</sup>

Энэ нь банкуудын зээлийн хүү өндөр байснаас тухайн эх үүсвэрийн хүүг төлөөд ашиг гаргах бололцоогүй, нөгөө талаас банкууд хөрөнгө оруулалтын зориулалтаар урт хугацааны, хүү багатай зээлийн үйлчилгээг зах зээлийн эрсдэл, эх үүсвэрээ богино хугацаанд татдагаас үүдэлтэй гарч болох төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа алдсанаас бий болох эрсдэл зэргээс хамааран бий болгохгүй байгаатай холбоотой юм. Энэ байдлаас харахад одоогийн нөхцөлд тухайн эх үүсвэрийг урт хугацаанд үр нөлөө нь гардаг, өгөөж багатай салбарт ашиглах нь тохиромжгүй бөгөөд харин богино хугацааны, өгөөж өндөртэй салбарт ашиглаж байна. Энэ утгаараа ч 2004 онд банкны зээлээр санхүүжсэн хөрөнгө оруулалт хурдацтай өссөн явдал нь банкууд өрхийн болон жижиг, дунд аж ахуйн

<sup>12</sup> 2004 онд нийт зээлийн хэмжээ 37.2 хувиар өсч 606.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд тухайн зээлийн өсөлт нь бүхэлдээ хувийн секторын зээлийн өсөлтөөр тодорхойлогдож хувийн секторын зээл 516.6 тэрбум төгрөгт хүрсэн. Тухайн оны зээлээрх хөрөнгө оруулалтын нийт зээлийн өсөлтөд эзлэх хувь нь 16.8% байна.

нэгжүүдэд зориулсан бичил, жижиг зээлийн үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн ажиллаж байгаа болон банкуудын том харилцагчдын хувьд хөрөнгө оруулалтын богино хугацааны эх үүсвэрийг илүүтэй ашигласантай холбоотой байж болох юм.

### 3.1.3 Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт

Манай орны хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж байгаа бөгөөд тухайн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулагдаж буй компаниуд нь салбарын өсөлт улмаар эдийн засгийн өсөлтөд нөлөөтэй байгаа эсэхийг судлахын тулд гадаад секторыг бий болгогч хөрөнгийн эх үүсвэр гадаад хөрөнгө оруулалт ямар байдалтай байгааг авч үзье.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт аль салбаруудад ямар хэмжээтэйгээр орсныг хавсралт 2-т үзүүлсэн бөгөөд харин салбаруудын нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтад эзлэх хувийг хүснэгт 3-т харуулаа. Хүснэгт 3-аас харахад 1990 он гэхэд зөвхөн худалдаа, нийтийн хоолны салбар (89.7%), соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэлийн салбарт (10.3%) л шууд хөрөнгө оруулалт орж байсан бол 1993 оноос эдийн засгийн бүх салбаруудад гадаадын хөрөнгө орж ирэх болсон байна. 1991-1993 онуудад нийт гадаадын хөрөнгө оруулалт 2.1-3.4 сая ам.доллар хүртэл өссөн бөгөөд салбараар нь авч үзвэл худалдаа нийтийн хоолны салбар (5.3-25.3%), хөнгөн үйлдвэрийн салбар (18.0-39.7%), мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын салбар (0.8-44.7%), ХАА-н салбар (2.3-27.9%), мебель, модон эдлэлийн салбар (5.9%)-уудад гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдэж байжээ.

Харин 1994-1996 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт 3.4 сая ам. доллараас 53.6 сая ам.доллар хүртэл өссөн бөгөөд харин хөрөнгө оруулалтын салбарын бүтэц өөрчлөгдөхөд 1994 оноос геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт хөрөнгө оруулалт орж ирэх болсон нь нөлөөлж, тус салбарт тухайн хугацаанд нийт хөрөнгө оруулалтын 7.1-21.5 % нь хийгдэж байсан бол мөн хөнгөн үйлдвэрийн салбарт 5.1-25.0%%, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын салбарт 15.8-18.8% нь орж, эдгээр салбарт нийт хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь орж байсан.

1996-2000 оны хооронд нийт гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах хандлага ажиглагдсан бөгөөд 1996-1998 онуудад уул уурхайн салбар (36.2-42.3%), инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар (9.9-16.1%) дахь хөрөнгө оруулалтын хэмжээ хурдацтай өсөж байсан бөгөөд харин бусад салбарууд дахь хөрөнгө оруулалт буурсан байна. 1997 оноос нийт хөрөнгө оруулалтын дийлэнх буюу 18.0-42.3% нь уул уурхайн салбарт хийгдэж байлаа. Харин хөнгөн үйлдвэр (оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн) -ийн салбарт 1999 онд 19.2 сая ам.доллар, 2000 онд 27.1 сая ам.долларын хөрөнгө оруулалт буюу нийт хөрөнгө оруулалтын 22.1% болон 29.0%-ийг эзэлж байсан бол мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын салбарт 1999, 2000 онуудад нийт хөрөнгө оруулалтын 9.6% болон 12.3 % нь орж байсан.

Эндээс аваад үзэхэд манай орны хувьд бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад нийт ГШХО-ын багахан хувь нь үйлдвэрлийн боловсруулах салбарт ордог байна.<sup>13</sup>

---

<sup>13</sup> Бусад эдийн засгуудын ГШХО-ын бүтцийг авч үзвэл Азид 62.9 хувийг боловсруулах салбарт, 33.6 хувийг үйлчилгээний салбарт оруулж байсан бол, жижиг хөгжиж буй орнуудын хувьд 28.8 хувийг боловсруулах салбарт, 55,5 хувийг үйлчилгээний салбарт, Африкын орнууд 26.6 хувийг боловсруулах салбарт, 19.8 хувийг үйлчилгээний салбарт, нийт эдийн засгийн хувьд 60.7 хувийг боловсруулах салбарт, 35.4 хувийг үйлчилгээний салбарт оруулж байсан байна. /UNCTAD, World Investment Report 1999/

### Хүснэгт 3. Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт: салбаруудын эзлэх хувь, 1990-2004 он\*

Салбар	(Хувиар (%))														
	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Геологи, уул уурхайн эрэл хайгуул, судалгаа, олборлолт	~	~	~	~	9.40	21.48	7.81	36.15	42.34	28.77	17.97	46.38	22.01	76.33	62.29
Худалдаа, нийтийн хоол	89.69	25.28	5.25	10.60	9.16	2.43	2.68	18.00	7.79	5.90	5.92	4.20	51.22	3.51	15.81
Хөнгөн үйлдвэр	~	~	39.69	18.00	24.98	5.07	22.46	3.70	10.49	22.07	28.97	4.02	1.65	2.39	8.86
Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт	~	0.84	14.14	44.70	15.81	18.79	16.83	3.24	4.92	9.55	12.34	5.10	0.17	0.21	1.42
Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл	~	4.74	~	0.95	12.55	4.37	8.37	9.90	16.11	6.56	8.68	6.64	3.42	1.21	1.28
Банк, санхүүгийн үйл ажиллагаа	~	~	~	~	~	0.05	8.18	0.60	0.21	2.51	0.75	16.06	2.29	0.06	1.03
Тээвэр	0.00	26.30	1.30	1.63	3.63	3.44	2.00	6.73	1.40	4.30	6.79	0.47	0.66	1.16	0.77
Харилцаа холбоо	~	~	~	1.31	1.67	28.39	3.37	0.18	0.01	3.54	0.08	0.13	0.25	2.08	0.50
Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	10.36	~	~	2.04	5.74	2.26	2.52	0.82	0.73	3.07	5.56	0.11	1.96	1.21	0.39
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	~	~	14.28	2.83	3.01	1.40	2.81	8.14	1.63	2.50	1.40	0.29	1.71	0.37	0.19
Аялал жуулчлал	~	~	0.26	2.18	5.01	0.76	14.52	0.60	0.65	0.24	0.32	0.08	0.41	0.42	0.18
ХАА, газар тариалан, МАА	~	27.93	2.26	5.07	0.24	0.71	1.54	3.26	3.10	3.82	0.27	0.67	0.20	0.04	0.11
Эрчим хүч	~	0.86	0.00	0.29	0.00	2.23	0.21	0.63	1.18	0.06	1.98	0.91	0.11	0.13	0.09
Мебель, модон эдлэл	~	0.00	4.04	5.85	0.15	1.01	0.10	0.36	0.36	1.07	0.71	0.89	0.51	0.26	0.04
Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	~	2.37	0.52	1.75	1.19	0.37	0.52	0.73	2.59	1.62	0.54	0.07	0.11	0.24	0.02
Нийтийн ахуйн үйлчилгээ	~	~	~	~	~	1.00	0.97	0.75	0.13	0.39	0.50	0.06	0.02	0.01	0.02
Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	~	~	1.84	2.01	0.58	0.03	1.40	0.02	0.11	0.44	0.03	0.00	0.01	0.09	0.01
Үнэт зүйлс, бэлэг дурсгал	~	~	~	~	1.22	0.03	0.07	0.16	2.19	~	0.01	0.03	0.00	0.03	0.01
Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	~	11.68	2.62	~	~	0.58	0.02	~	0.01	0.21	0.05	0.05	0.08	0.18	0.01
Бусад	~	~	13.78	0.77	5.67	5.59	3.63	6.02	4.05	3.37	7.14	13.85	13.21	10.03	6.97
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх үүсвэр: Үндэсний статистикийн газар

\*-УСГ, ГШХО нь гадны хөрөнгө оруулагчид "Гадаадын хөрөнгө оруулалтын газар"-аас компани байгуулах зөвшөөрөл авахдаа амалсан хөрөнгө оруулалтын дүн болно.

2001 оноос хойш уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт хурдацтай өсөх болсон бөгөөд энэхүү өсөлт нь нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлтийн дийлэнх хувийг эзэлсээр ирсэн байна. Уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт 2001-2004 оны хооронд 56.9 -147.6 сая ам.доллар хүртэл өссөн буюу 2.5 дахин өсөж, нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтад эзлэх хувь нь 22.0-76.3% хүртэл өссөн байна. Мөн худалдаа, нийтийн хоолны салбарт 2002 онд 89.5 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө орсон бөгөөд энэ нийт хөрөнгө оруулалтын 51.2%-ийг эзэлж байсан бол 2004 онд 15.8%-ийг эзэлж байжээ. Харин хөнгөн үйлдвэрийн салбар дах хөрөнгө оруулалт 2001-2003 онуудад буурах хандлагатай байсан бол 2004 онд 21.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт орж 8.9%-ийг эзлэх болж өссөн байна.

Эдгээрээс нэгтгэн авч үзэхэд манай орны хувьд сүүлийн жилүүдэд нийт хөрөнгө оруулалт хурдацтай өсөж буйн дээр нийт хөрөнгө оруулалтын өсөлтийг гадаадын хөрөнгө оруулалтын өсөлт бий болгож, гадаадын нийт хөрөнгө оруулалтад гадаадын шууд хөрөнгө оруулалтын эзлэх хувь дийлэнх хэсгийн бүрдүүлж байна. Шууд хөрөнгө оруулалтыг салбарын бүтцээр нь авч үзэхэд уул уурхайн салбар (17.8-72.3%), худалдаа нийтийн хоолны салбар (4.2-51.2%), хөнгөн үйлдвэр (1.7-29.0%), инженерийн барилгын байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл (1.2-16.1%), мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт (0.2-12.3%), банк санхүүгийн үйл ажиллагаа (0.1-16.1%) салбаруудад орсон байна. Энэхүү гадаадын шууд хөрөнгө оруулалтаар байгуулагдсан компаниудыг салбарын бүтцээр нь авч үзвэл салбаруудад зарим онуудад хийгдсэн том хөрөнгө оруулалтууд нь тухайн салбарт хичнээн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бий болгосон тухай мэдээллийг харах боломжийг бий болгоно. Иймд гадаадын шууд хөрөнгө оруулалтаар байгуулагдсан компаниудын тоог хавсралт 3-т үзүүлээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд мөн л дээрхийн адил гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ болон нийт хөрөнгө оруулалтад өндөр хувь эзэлдэг салбаруудын хувьд мөн тэр хэмжээгээр олон тооны компаниуд байгуулагдаж байгааг гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниудын тоо 1996 онд жилд 190 байгуулагдаж байсан бол 2003 онд 653 компани, 2004 онд 732 компани болж өссөн зэргээс харж болно. Тэгэхдээ салбарын онцлогоос хамааран шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нь хэмжээний огцом өсөлт, өндөр дүнгээс хамааран компаниудын тоо өснө гэж шууд ойлгож болохгүй нь зүйн хэрэг юм. Учир нь сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт нийт гадаадын хөрөнгө оруулалтыг тодорхойлж байхад тухайн салбарт жилд дунджаар 16-34 гадаадын шууд хөрөнгө оруулалттай компани байгуулагддаг байна. Харин худалдаа, нийтийн хоолны салбарт хамгийн их буюу 2001 онд 96 компани, 2002 онд 115 компани, 2003 онд 217 компани байгуулагдаж байжээ.

Хавсралт 3-аас харахад салбаруудын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтаар байгуулагдсан компаний тоо нь жил бүр харьцангуй тогтвортой бөгөөд харин худалдаа нийтийн хоолны салбар, инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар, аялал жуулчлалын салбарт сүүлийн жилүүдэд шинээр байгуулагдах компанийн тоо өмнөх жилүүдээс огцом өсөх хандлагатай байхад мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт, тээвэр, хөнгөн үйлдвэрийн салбаруудын хувьд харин шинээр байгуулагдах компаниудын тоо буурах болсон байна.

Ерөнхийдөө гадаадын шууд хөрөнгө оруулалттай нийт компаниудын тоо 1996-аас 2002 оныг хүртэл аажмаар өсөж байсан бөгөөд энэхүү өсөлт нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлттэй ижил чиглэлд буюу 1 компани дахь дундаж хөрөнгө оруулалт адил байгаа бөгөөд мөн 2002 оноос хойш шууд хөрөнгө оруулалтын өсөлттэй адилаар компаниудын тоо өссөн нь нэг компанид ноогдох дундаж хөрөнгө оруулалт мөн л тогтвортой байгааг илэрхийлж байна. Харин хөрөнгө оруулалтын хувьд сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өсөн,

байгуулагдах компанийн тоо цөөрөх хандлагатай байгаа нь 1 компанийн байгуулагдаж буй өөрийн хөрөнгө өндөр байгаа болон өмнөх байгуулагдсан компаниудад хөрөнгө оруулалт дахин хийж хөрөнгийн эрчимжилт явагдаж буйг илэрхийлж байгаагийн дээр, худалдаа нийтийн хоолны салбарын хувьд хөрөнгө оруулалтын өсөлт, тооны өсөлттэй давхцаж буй тул ийм дүр зураг харагдахгүй байна.

Харин гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг орон нутгийн байршлаар авч үзсэн байдлыг хавсралт 4-д үзүүлсэн бөгөөд Улаанбаатар хотод орсон хөрөнгө оруулалт нь 1996-аас 2003 оны хооронд 49.9 сая ам.доллараас 194.3 сая ам доллар хүртэл өссөн буюу нийт хөрөнгө оруулалтын 93.1-98.7 % нь орж байсан байна. Аймгуудын хувьд Орхон аймаг, Дорнод аймаг, Дархан уул аймаг, Өмнөговь аймаг, Төв аймгуудад бусад аймгийг бодвол томоохон хэмжээний шууд хөрөнгө оруулалтууд орсон бөгөөд харин үлдсэн аймгуудын хувьд тухайн онд манай оронд хийгдсэн шууд хөрөнгө оруулалтын 1% хүрэхгүй хэсэг нь ордог байна.

Орон нутгийн байршлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтаар байгуулагдаж байгаа компанийн тоог авч үзэхэд (хавсралт 6-д үзүүлэв) мөн л дийлэнх хэсэг нь Улаанбаатар хотод байгуулагдаж байгаа бөгөөд 1996 онд 175 компани байгуулагдаж байсан бол хөрөнгө оруулалтын хэмжээ өсөхийн хэрээр шинэ компаниуд байгуулагдаж байгаа бөгөөд 2003 онд 639 компани байгуулагдсан байна. Аймгуудын хувьд жил бүхэн тогтмол гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд байгуулагддаггүй бөгөөд харьцангуй аж үйлдвэр, геологи, уул уурхайн орд газартай, байгалийн нөөц баялагтай аймгуудын хувьд хөрөнгө оруулалтын хэмжээ бусад аймгаас илүү байдагтай холбоотойгоор тухайн аймгуудад зарим жилд 1-8 хүртэл компани байгуулагдаж байсан бол бусад аймгуудын хувьд жилд дундажаар 1 компани байгуулагддаг байна.

Манай улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг ямар орнууд хэдий хэмжээгээр оруулж байгааг хавсралт 7-д харууллаа. Эндээс аваад үзэхэд 1990 оны эхээр анхны томоохон хөрөнгө оруулагчид нь урд хөрш БНХАУ, Япон зэрэг орнууд байсан бол одоогоор манай оронд 70 орчин орнууд их бага хэмжээний хөрөнгө оруулалт оруулж байна. Манай оронд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтыг улсуудаар авч үзвэл БНХАУ (0.1-135.3 сая ам.доллар), Канад (0.01-120.1 сая ам.доллар), БНСУ (1.3-23.0 сая ам.доллар), Япон (0.07-17.1 сая ам.доллар), АНУ (0.09-10.3 сая ам.доллар), ОХУ (0.03-6.4 сая ам.доллар) зэрэг нийт хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг оруулдаг байна. Эндээс аваад үзэхэд тухайн улсуудын хөрөнгө оруулалтын хэмжээний интерваль хол байгаа нь жижиг эдийн засагтай оронд донор орнуудаас оруулдаг хөрөнгө оруулалт тогтвортой бус, их хэлбэлзэлтэй байдгийг нотолж байна.

Манай орны гадаадын нийт хөрөнгө оруулалттай компаниудад аль орнын компаниуд давамгайлах шинжтэй байгааг авч үзэхэд БНХАУ-ын хөрөнгө оруулалт нь нийтийн хоолны салбар болон Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбаруудад түлхүү ордог бөгөөд энэ утгаараа сүүлийн жилүүдэд тухайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулагчтай компаниудын дийлэнх нь БНХАУ-ын компаниуд (56-322) байдаг бол Канад улсын хувьд геологи уул уурхайн салбарт түлхүү орж тухайн салбар дахь шууд хөрөнгө оруулалттай компаниудын дийлэнх (17-125) нь тухайн том хөрөнгө оруулагч орнуудынх байна.

### **3.2 Гадаад шууд хөрөнгө оруулалт, шууд хөрөнгө оруулалттай компаниудын эдийн засагт үзүүлж буй нөлөө**

Тухайн хэсэгт эдийн засгийн салбаруудад орж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт нь тухайн салбаруудын өсөлтөд нөлөөтэй байна уу, хэрэв нөлөө байгаа бол энэ нь тухайн салбарын эдийн засагт эзлэх байр суурь болон нийт эдийн

засгийн өсөлтөд нөлөөтэй байж чадаж байна уу гэдэг асуултад хариулахыг оролдох болно.

### **3.2.1 Монголын эдийн засгийн салбарын бүтэц, салбаруудын өсөлт**

Эдийн засаг дахь гадаад секторын оролцоог ялган харахын тулд салбар бүр дэх гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд салбарын нийт үйлдвэрлэлийн хичнээн хувийг үйлдвэрлэж байгаа, салбарын өсөлтөд гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниуд буюу гадаад секторын үйлдвэрлэлийн өсөлт хичнээн хувийг бий болгож, улмаар нийт эдийн засгийн өсөлтөд нийт гадаад секторын үйлдвэрлэлийн өсөлт ямар хувь эзэлж байгааг гарган судлах нь чухал юм.

Гэвч энэхүү байдлаар салбар, нийт эдийн засгийн үйлдвэрлэл, өсөлтийг салган тодорхойлох тоон мэдээллийн боломж манай орны хувьд тун хязгаарлагдмал бөгөөд тухайн хэсгийн хувьд тоон мэдээллийн боломжийн хүрээнд салбарууд дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтаар шинээр байгуулагдаж байгаа болон үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын эцсийн дүндээ гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дамжин орж, түүний нөлөө нь тухайн жилдээ, хугацааны хоцрогдолтойгоор нөлөөлж болох юм гэж үзэн харьцуулалтыг хийлээ.

Ийнхүү харьцуулан судлахын тулд салбаруудын өсөлт, нийт эдийн засгийн өсөлтөд салбаруудын өсөлтийн эзлэх хувь ямар байдалтай байгаа авч үзэх хэрэгтэй бөгөөд салбаруудын эдийн засагт эзлэх хувийг хавсралт 5-д үзүүлээ. 1996 он хүртэл манай орны эдийн засгийн дийлэнх хэсгийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байсан бөгөөд ган, зуд болон байгалийн нөхцөл байдлаас хамааран тухайн салбарын өсөлт, бууралт нь нийт эдийн засгийн өсөлтөд хүчтэй нөлөө үзүүлж байсан. Харин 1997-2003 оны хооронд ХАА-н салбарын нийт эдийн засагт эзлэх хувийн жин 37.5%-аас 20.1% хүртэл буурсан нь манай орны газар тариалангийн салбар өссөн хэдий ч түүний эзлэх хувь бага байдгаас МАА-н салбарт 2000-2002 оны дараалсан зуд болсон нь нөлөөлсөн бол харин тухайн үед үйлчилгээний салбар 37.8%-аас 54.6% болтлоо өссөн бөгөөд энэхүү өсөлтөд бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйг бараа засварлах үйлчилгээний салбар 21.0%-аас 24.6% хүртэл өссөн, Тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбар 7.7%-аас 13.9% хүртлээ өссөн, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа 1.6%-аас 3.8 % хүртлээ өссөн, боловсролын салбарын үйл ажиллагаа 2.7%-аас 4.5 % хүртлээ өссөн зэрэг нь гол нөлөө үзүүлжээ.

2004 онд өмнөх жилүүдэд ажиглагдаж байсан салбаруудын ДНБ-нд эзлэх хувийн жинд өөрчлөлт гарсан бөгөөд ХАА-н салбарын эзлэх хувь буцаж өсөн 21.3%, Аж үйлдвэрийн салбар өсөн 28.2%-д хүрч, үйлчилгээний салбарын эзлэх хувь 50.6 хувь хүртэл буурсан байна. Аж үйлдвэрийн салбарын энэхүү эзлэх хувийн өсөлтөд бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын эзлэх хувийн бууралт, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарын эзлэх хувийн бууралт нөлөөлөсөн бол аж үйлдвэрийн салбарны эзлэх хувийн өсөлтөд уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувийн өсөлт гол нөлөө үзүүлжээ. 2005 оны эхний 8 сарын байдлаар аж үйлдвэрийн салбар дотроо уул уурхай, олборлох салбарын эзлэх хувь 66.4%, боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь 20.7%, цахилгаан эрчим хүч дулааны үйлдвэрлэл, усан хангамжийн эзлэх хувь 12.9 % байсан байна.

Хүснэгт 4-т нэг хүнд ногдох ДНБ-ний хэдий хэмжээг нь аж үйлдвэр, ХАА, үйлчилгээний салбарууд үйлдвэрлэж байгааг манай оронтой ойролцоо нэг хүнд ногдох ДНБ-тэй, шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулан харууллаа.

#### Хүснэгт 4. Нэг хүнд ногдох ДНБ-ний салбаруудаарх задаргаа

ам.доллараар

	Гүрж			Узбекистан			Киргиз			Монгол		
	АҮ	ХАА	Үйлчилгээ	АҮ	ХАА	Үйлчилгээ	АҮ	ХАА	Үйлчилгээ	АҮ	ХАА	Үйлчилгээ
1994	58.9	79.3	93.7	50.6	97.1	107.8	51.5	96.4	127.5	102.1	115.7	140.8
1995	74.9	159.4	300.7	80.9	129.4	194.1	40.4	137.0	196.9	142.7	197.2	179.0
1996	64.2	152.0	346.8	108.2	140.7	292.1	43.9	184.4	206.6	87.4	179.8	143.3
1997	82.1	233.2	341.6	86.8	132.6	237.7	63.3	157.5	165.2	116.4	159.5	168.4
1998	91.7	238.2	441.0	94.0	116.4	237.3	57.1	126.2	171.3	81.4	146.7	163.2
1999	68.1	146.7	309.2	70.3	94.7	173.2	57.8	92.7	119.7	74.9	134.5	154.2
2000	90.3	133.1	435.6	52.0	98.8	215.2	67.4	98.9	122.9	84.4	112.2	188.8
2001	84.5	143.5	465.0	43.1	91.8	171.1	82.5	136.4	102.1	83.5	94.1	200.3
2002	91.0	141.7	501.3	46.5	101.0	182.5	71.1	114.9	148.0	100.1	92.1	252.8
2003	113.6	173.4	567.1	-	-	-	82.6	139.0	173.4	126.9	100.4	272.2
2004	-	-	-	-	-	-	-	-	-	166.3	125.6	297.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар, European Bank for Reconstruction and Development (EBRD), "Transition report 2002 and 2004"

Хүснэгт 4-өөс харахад нийт нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээр манай улс Гүрж улсаас доогуур харин Узбекистан болон Киргиз улсуудаас дундажаар 90.8-121.2 ам.доллараар өндөр байна. Манай орны аж үйлдвэрийн салбарын нэг хүнд ногдох үйлдвэрлэл нь Гүрж улстай ойролцоо, ХАА-н салбарын үйлдвэрлэлийн хувьд Узбекистан болон Киргиз улсын үйлдвэрлэлтэй ойролцоо, харин үйлчилгээний салбарын хувьд Узбекистан улсын хэмжээтэй ойролцоо байдалтай явж байна. Мөн Гүрж улсын хувьд нэг хүнд ногдох орлогын дийлэнх хэсгийг нь буюу сүүлийн жилүүдэд дундажаар 492.2 ам долларыг буюу дийлэнх хэсгийг нь үйлчилгээний салбар бий болгодог бөгөөд энэ хандлага эдгээр 4-н орны хувьд хадгалагдаж байна. Харин салбаруудын орлого бий болгож байгаа ялгаа нь Гүрж, Узбекистан, Киргизийн хувьд хол байгаа бөгөөд харин манай орны хувьд энэ байдал нь бага буюу салбаруудын бий болгож байгаа нэг хүнд ногдох орлого ойролцоо түвшинд байна.

Эдийн засгийн нийт болон салбаруудын бодит өсөлт<sup>14</sup> ямар байдалтай байгааг хүснэгт 5-д харууллаа. 1996-1997 онуудад ХАА-н салбар 4.4%- 4.3%-аар өссөн бөгөөд харин аж үйлдвэрийн салбар уналтад байсан буюу өсөлт нь харгалзан -3.2%- -3.3% өссөн буюу үүнээс уул уурхай, олборлох салбар 6.1% болон 5.6% өсөлттэй байсан хэдий ч, боловсруулах үйлдвэрийн өсөлт (-13.8%)-(-15.0%) болтлоо буурсан нь нөлөөлсөн бол үйлчилгээний салбар 4.9%-8.5% өссөн бөгөөд үүнд 1996 онд тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбар 11.2%, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа 42.2%, боловсролын үйл ажиллагаа 4.0% өссөн зэрэг нь нөлөөлсөн бол 1997 онд бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн бараа засварлах үйлчилгээ 17.1%, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбар 5.8%, боловсролын үйл ажиллагаа 4.1% өссөн зэрэг нь нөлөөлсөн байна.

1998-2001 оны хооронд ХАА-н салбарын өсөлт 6.4%-аас -19.0% хүртэл буусан буюу уналтад орж тухайн салбарын нийт эдийн засагт эзлэх хувийн жин буурах болсон бол аж үйлдвэрийн салбар харин 1998, 2001 онуудад өсөлттэй буюу 3.8%-16.2%-ийн өсөлттэй байхад уул уурхайн салбар 4.9%-аас 10.1% хүртэл өссөн, боловсруулах үйлдвэр 3.2%-аас 31.8% хүртэл өссөн нь нөлөөлсөн бол харин үйлчилгээний салбар 1998 онд өсөлтгүй буюу -0.1% байсан бол 2000 онд 18.6%, 2001 онд 8.2 % өссөн бөгөөд энэхүү өсөлтөд бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн бараа засварлах үйлчилгээ -3.1%-аас 10.1% хүртэл өссөн, тээвэр агуулах аж ахуй, холбооны салбар 1998 онд 7.4%, 2000 онд 25.2%%,

<sup>14</sup> Бодит өсөлт гэдгийг салбарын болон эдийн засгийн орлогын өсөлт бус үнийн нөлөөг арилгасан бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээний өсөлт гэж ойлгоно. (1995 зэрэгцүүлэх үнэд шилжүүлэн тооцсон)



2001 онд 14.9% -аар өссөн явдал нөлөөлжээ. Тухайн хугацаанд нийт эдийн засгийн өсөлт буурах хандлагатай байсан бөгөөд 1998 онд 3.5% байсан бол 2001 он гэхэд 1.0% болсон энэхүү эдийн засгийн өсөлтийн бууралтад аж үйлдвэрийн болон үйлчилгээний салбаруудад өсөлт ажиглагдаж байсан ч 2000- 2001 оны ХАА-н салбарт гарсан дараалсан зуд нь тухайн салбарыг уналтад оруулсантай холбоотой бөгөөд тухайн онуудын эдийн засгийн өсөлтөд салбаруудын эзлэх хувийг авч үзвэл ХАА-н салбар 1998 онд 70.3 %, 1999 онд 52.3%, эзэлж өсөлтөд эерэг нөлөөлж байсан бол 2000 онд -552.0% 2001 онд -630.8% болж хүчтэй сөрөг нөлөөлөх болсон.

#### Хүснэгт 5. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөлтийн хувь, салбараар, 1996-2005.VIII\*

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005 VIII
<b>Дотоодын нийт бүтээгдэхүүн</b>	<b>2.4</b>	<b>4.0</b>	<b>3.5</b>	<b>3.2</b>	<b>1.1</b>	<b>1.0</b>	<b>4.0</b>	<b>5.6</b>	<b>10.6</b>	~
<b>Хөдөө аж ахуйн салбар</b>	<b>4.4</b>	<b>4.3</b>	<b>6.4</b>	<b>4.2</b>	<b>-14.4</b>	<b>-19.0</b>	<b>-10.7</b>	<b>5.8</b>	<b>18.9</b>	~
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	4.4	4.3	6.4	4.2	-14.4	-19.0	-10.7	5.8	18.9	~
<b>Аж үйлдвэрийн салбар</b>	<b>-3.2</b>	<b>-3.3</b>	<b>3.8</b>	<b>1.1</b>	<b>1.6</b>	<b>16.2</b>	<b>5.4</b>	<b>3.0</b>	<b>15.4</b>	<b>-8.3</b>
Уул уурхай, олборлох үйлдвэр	6.1	5.6	4.9	3.2	6.1	10.1	-6.9	-1.3	31.9	6.6
Боловсруулах үйлдвэр	-13.8	-15.0	3.2	-2.8	-3.3	31.8	22.1	2.1	1.5	-27.3
Цахилгаан эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	0.7	0.4	3.2	4.6	0.4	3.5	3.9	1.1	6.3	2.6
Барилга	2.6	-2.7	-1.1	1.6	-14.6	10.8	18.5	47.6	0.3	~
<b>Үйлчилгээний салбар</b>	<b>4.9</b>	<b>8.5</b>	<b>-0.1</b>	<b>3.6</b>	<b>18.6</b>	<b>8.2</b>	<b>12.2</b>	<b>7.1</b>	<b>4.0</b>	~
Бөөний болон жижиглэнгийн худалдаа, гар ахуйн бараа засварлах үйлчилгээ	0.3	17.1	-3.1	1.3	25.7	10.1	13.3	7.1	2.8	~
Зочид буудал, зоогийн газар	6.8	0.2	0.5	8.7	13.2	-6.9	4.6	0.5	6.6	~
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	11.2	5.8	7.4	6.1	25.2	14.9	16.2	13.9	9.0	~
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	42.2	-26.7	-33.0	39.9	7.0	22.4	7.3	33.6	20.2	~
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйлчилгээ	4.2	-2.4	8.4	-4.7	12.5	7.1	25.2	30.6	3.1	~
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	3.5	2.2	1.9	1.5	3.5	-5.7	-0.4	-2.5	-9.7	~
Боловсролын салбарын үйл ажиллагаа	4.0	4.1	6.8	4.6	3.2	1.3	4.9	-5.5	2.5	~
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	4.4	3.0	1.4	3.1	-2.7	7.4	2.9	-2.4	-0.6	~
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	0.8	6.2	5.3	0.5	57.1	10.4	49.2	-0.1	1.6	~
Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	15.6	-7.5	-16.6	7.0	30.5	27.1	1.6	27.4	11.3	~

\*- 2005 оны 8 дугаар сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний мэдээлэл гарсан бөгөөд бусад мэдээлэл гараагүй байсан болно.

Эх үүсвэр: Үндэсний статистикийн газар

2002-2004 оны хооронд нийт эдийн засгийн өсөлт буцаж сэргэж 2002 онд 4.0%, 2003 онд 5.6%, 2004 онд 10.6%-д хүрч өссөн бөгөөд энэхүү өсөлтийг бий болгоход салбаруудын дотоод өсөлт ямар байдалтай байгааг авч үзвэл ХАА-н салбар 2002 онд мөн л уналттай байсан бөгөөд 2003 оноос өсөлт ажиглагдаж 5.6%, 2004 онд 18.9% байжээ. Харин аж үйлдвэрийн салбарын хувьд 2002 онд 5.4%, 2003 онд 3.0% болж өсөлт нь саарсан хэдий ч 2004 онд 15.4 % болж өссөн. Энэхүү өсөлтийг дэд салбараар нь авч үзвэл уул уурхай, олборлох үйлдвэр 2002-2003 онуудад уналттай байж, 2004 онд 31.9 %, 2005 оны эхний 8 сарын байдлаар 6.6% өссөн бол боловсруулах үйлдвэрийн салбарын хувьд 2002 онд 22.1%, 2003 онд 2.1%, 2004 онд 1.5 % болж сарах хандлагатай байсан бол 2005 оны эхний 8 сарын байдлаар -27.3% болж уналтанд орсон байна.

Тус салбар ийнхүү 2005 сарын оны байдлаар уналтанд ороход нэхмэлийн үйлдвэрийн салбар -36.7%-аар уналтанд орсон нь голлон нөлөөлсөн байна. Үйлчилгээний салбарын хувьд 2002 онд 12.2%, 2003 онд 7.1%, 2004 онд 4.0 % өсөж ерөнхийдөө саарах хандлага ажиглагдсан бөгөөд энэхүү өсөлтийн гол шалтгаан нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн бараа засварлах үйлчилгээний салбар 13.3%-аас 2.8% болтлоо буурч, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарын өсөлт 16.2%-аас 9.0 % болж буурсан зэрэгтэй шууд холбоотой байна.


Сүүлийн 3 жилийн эдийн засгийн өсөлтөд салбаруудын эзлэх хувийг авч үзэхэд 2002 онд хэдийгээр ХАА-н салбар уналттай -72.1%, аж үйлдвэрийн салбарын уул уурхай, олборлох үйлдвэр мөн уналттай -24.9% байсан хэдий ч боловсруулах үйлдвэрийн өсөлт 53.3%-ийг, бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн бараа засварлах үйлчилгээний салбар 76.8%, ч, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарын өсөлт нийт өсөлтийн 42.3 %-ийг эзлэх болсноор эдийн засаг 4.0%-ийн өсөлттэй гарсан бол 2003- 2004 онуудад ХАА-г салбарын өсөлтөд эзлэх хувь 24.1-42.1% байжээ.

2003 оны 5.6%-ийн өсөлтийг үндсэнд нь ХАА-н салбар, боловсруулах үйлдвэрийн салбар, бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн бараа засварлах үйлчилгээний салбар, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбаруудын өсөлт тодорхойлсон бол 2004 оны 10.6 хувийн өсөлтийг гол нь ХАА-н салбар, аж үйлдвэрийн салбараас уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар үүн дотроо металлын хүдэр олборлолтын алтны компаниудын олборлолт, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбаруудын өсөлт бий болгосон байна.

### 3.2.2 Салбаруудад орж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт, шууд хөрөнгө оруулалттай компаниудын салбарын болон эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөө

Эдийн засгийн салбаруудад орж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт нь тухайн салбаруудын өсөлтөд нөлөөтэй байна уу гэдгийг харахын тулд салбаруудад оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын 3.1.3 хэсэг болон эдийн засгийн салбаруудын бүтэц, өсөлтийг авч үзсэн 3.2.1 хэсгүүдэд дурьдсан зүйлсийн хооронд хамаарал, холбоо байгаа эсэхийг нэгтгэн авч үзэх болно.

Зураг 1-д ГШХО болон ДНБ-ний өсөлтийн динамик хандлагыг харуулсан бөгөөд зургаас харахад эдгээрийн хөдөлгөөн нь ижил чиглэлд хөдөлж байгаа буюу ГШХО өссөн үед ДНБ-ий өсөлт, буурсан үед уналт ажиглагдаж байна. Эндээс харахад манай орны хувьд онолын хэсэгт тодорхойлсон ГШХО болон ДНБ-ний өсөлтийн хооронд эерэг хамаарал байгаа болох нь нотлогдож байна.



Эх үүсвэр: УСГ-ын тоон мэдээлэл ашиглан тооцсон тооцоо

Дараагийн хэсэгт салбар тус бүрд оруулсан ГШХО болон тухайн салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн хооронд хамаарал байгаа эсэхийг салбар тус бүрээр нь авч үзсэн. Манай орны хувьд ХАА-н салбар нь эдийн засагт 1997 оныг хүртэл тэргүүлэх салбар байсан бөгөөд ХАА-н салбар дотроо газар тариалангийн салбар нь 1990 оны эхээр нийгэм, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хувьчлалын дараа уналтад орох хандлага ажиглагдсан нийт эдийн засагт эзлэх хувь нь бага, харин МАА-н салбарын хувьд хувьчлалын дараагаар иргэд хувийн өмчийн малаа илүү өсгөх сонирхол эрмэлзэл, ган зудын бэрхшээл бага байснаас эдийн засагт дийлэнх хэсгийг бүрдүүлэх болсон.

Тэгэхдээ МАА-н салбар үндсэндээ уламжлалт мал аж ахуй эрхлэлттэй, газар тариалангийн хувьд мөн эрчимжсэн аж ахуйн фермерүүд байдаггүй, МАА-н салбарын хувьд малын онцлог, шинж нь фермерийн аж ахуй байгуулах боломжгүй зэргээс гадаадын хөрөнгө оруулалт тухайн салбарт тийм ихээр орж ирдэггүй байна. Энэ утгаараа тухайн салбарын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагчтай компанийг салбарын өсөлттэй холбон авч үзэх нь тохиромжгүй бөгөөд харин ган, зуд, хадлан, малын гоц халдварт өвчин зэрэгтэй холбон судалбал илүү тохиромжтой юм.

Гэвч сүүлийн жилүүдэд эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйн фирмерүүд байгуулагдах болсноор тухайн салбарын өсөлтөд нөлөө үзүүлэх (тэр дундаа үр тарианы тариалалт) хандлага ажиглагдаж байгаа бөгөөд тухайн салбарт 1997 онд 1.3 сая ам. доллар, 1998 онд 1.4 сая ам доллар, 1999 онд 3.3 сая ам долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтаар 1997 онд 11 компани, 1998 онд 19 компани, 1999 онд 14 компаниуд байгуулагдаж байсан бол 2000 оноос хойш хөрөнгө оруулалтын хэмжээ илт буурах болж компанийн тоо цөөрөх болсон. (Хавсралт 2, хавсралт 3-аас харна уу.)

Тухайн үед ХАА-н салбарын өсөлт нь 1997-1999 онуудад 4.3%, 6.4%, 4.2% байсан бөгөөд хүснэгт 7-д харуулснаар ГШХО-ын тухайн салбарын үйлдвэрлэлд үзүүлэх мэдрэмжийг 1993-2004 оны тоон мэдээлэл дээр тооцоход 0.25 гарч байгаа бөгөөд эндээс харахад тухайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт өсөхөд тухайн салбар ерөнхийдөө өсдөг байна. Энэ нь дээрх ХАА-н салбарын онцлогоос хамааран гадаадын хөрөнгө оруулалт, тухайн хөрөнгөөр байгуулагдаж буй компанийн нөлөө бараг байдаггүйг харуулж байна.

#### **Хүснэгт 6. Салбаруудын ГШХО-аас хамаарсан ДНБ-ний мэдрэмж<sup>15</sup>**

ХАА-н салбар	Аж үйлдвэрийн салбар	Үйлчилгээний салбар
0.25	0.29	0.29

Эх үүсвэр: ҮСГ-аас гаргасан ДНБ болон ГШХО-ын 1993-2004 оны тоон мэдээлэл ашиглан үнэлсэн үнэлгээ

Харин аж үйлдвэрийн салбарын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь ордог. Үүнд дотроо уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар дахь хөрөнгө оруулалт дийлэнх хувийг эзэлдэг бөгөөд тухайн салбар дахь хөрөнгө оруулалт 2000 онд 16.8 сая ам.доллар, 2001 онд 56.9 сая ам.доллар, 2002 онд 38.5 сая ам. долларын хөрөнгө оруулалт оруулж байсан бол 2003 онд огцом өсөж 150.2 сая ам.доллар, 2004 онд 147.6 сая ам. доллар хүртлээ хөрөнгө оруулалт өсөн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд жилд дунджаар 16-38 компаниуд байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд энэ хугацаанд тухайн салбарын өсөлт нь 2000 онд 6.1%, 2001 онд 10.1%-ийн өсөлттэй байсан хэдий ч 2002 онд -6.9%, 2003 онд -1.3% болж уналтад орж 2004 онд буцан 31.9% өсөж, 2005 оны эхний 8 сарын байдлаар 6.6% өссөн байдалтай байна.

<sup>15</sup> Тус мэдрэмж нь богино хугацаанд ХАА-н салбарт орж ирж байгаа ГШХО нэг хувь өсөхөд ХАА-н салбарын үйлдвэрлэл 0.25 хувиар өснө, аж үйлдвэрийн салбарын ГШХО нэг хувь өсөхөд тус салбарын үйлдвэрийн үйлдвэрлэл 0.29 хувиар өсөх, үйлчилгээний салбарт ГШХО нь нэг хувь нэмэгдэхэд үйлчилгээний салбарын үйлдвэрлэл 0.29 өснө гэдгийг илэрхийлнэ.

Эндээс харахад гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухайн салбарын үйлдвэрллийн хэмжээнд үзүүлэх мэдрэмжийг 1995-2004 оны тоон мэдээлэл дээр тооцоход 0.29 гарч байгаа бөгөөд эндээс харахад тухайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт өсөхөд тухайн салбарын үйлдвэрлэл ерөнхийдөө өсдөг гэсэн онолын холбоо ажиллаж байна. Харин 2004 оны хувьд аж үйлдвэрийн салбарын өсөл нь нийт эдийн засгийн өсөлтөд үндсэн байр эзэлсэн бөгөөд үүн дотроо олборлох аж үйлдвэрийн салбарын металлын хүдэр олборлолтын алтны гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын (1997 онд Канадын хөрөнгө оруулалттай "Бороо Гоулд" ХХК) үйлдвэрллийн өсөлт, дэлхийн зах зээлийн үнийн өсөлт зэрэг хүчин зүйлс голлох нөлөө үзүүлсэн байна. Эндээс аваад үзэхэд энэ салбарын хувьд 1997 оноос томоохон хөрөнгө оруулалт орж эхэлсэн бөгөөд тухайн компаниудын үйлдвэрлэлийн өсөлт нь салбарын өсөлтөдөө тус салбартаа эзлэх хувийнхаа хэмжээгээр 3-5 жилийн хугацааны хоцрогдолтойгоор нөлөөлж байж болохоор байна.

Боловсруулах үйлдвэрийн салбарын хувьд хөнгөн үйлдвэрт сүүлийн жилүүдэд 2.9-27.1 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар 6-37 хөрөнгө оруулалттай компаниуд байгуулагдсан бол мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын салбар 0.3-11.6 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар жилд дундажаар 3-23 гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниуд байгуулагдаж байсан бөгөөд тухайн цаг хугацаанд салбарын өсөлт нь 1999-2000 онуудад уналттай байсан бол 2001-2002 оны хувьд сайн өсөлттэй буюу 31.8-22.1% байсан бол 2003-2004 оны хооронд өсөлт саарч 2.1-1.5% болсон байна. Эндээс харахад томоохон хөрөнгө оруулалт орж буюу компаниуд байгуулагдсанаар 2-3 жилийн дараагаар тухайн салбарын өсөлтөд нөлөө үзүүлсэн байна. Энэ нь тухайн компанийн үйл ажиллагаа тогтворжиж, идэвхижиж бүрэн боломжоороо ажиллах түүхий эдийн бэлтгэлийн шаардагдах хугацаа зэрэгтэй холбоотой байж болно.

Үйчилгээний салбарын хувьд гол байр суурь эзэлдэг салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, зочид буудал, зоогийн газрын салбарууд бөгөөд тус салбарт 1997-2001 оны хооронд жилд дундажаар 3.6-7.3 сая ам. долларын хөрөнгө оруулалтаар 44-96 гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниуд байгуулагдаж байсан бол 2002 онд 89.5 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар 115 компани байгуулагдсан бол 2003 онд 6.9 сая ам.доллар, 2004 онд 37.5 сая ам долларын хөрөнгө оруулалтаар 2003 онд 217 компани байгуулагдан үйл ажиллагаа явуулах болсон бөгөөд эндээс тус салбарт 2002 онд нэг компанид ногдох дундаж хөрөнгө оруулалт хамгийн өндөр байгаа бөгөөд томоохон компаниуд байгуулагдсан байна. Энэхүү хугацаанд салбарын өсөлт нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын хувьд 1997 онд 17.1%, 1998-1999 онуудад -3.1-1.3%, 2000 онд огцом өсөж 25.7%-д хүрсэн бол 2001 онд 10.1%, 2002 онд 13.3% байж 2003 оноос өсөлт нь буурах хандлага ажиглагдаж 7.1%, 2004 онд 2.8%-ийн өсөлттэй байсан бол зочид буудал, зоогийн газрын салбарын хувьд 1997-1998 онд 0.2-0.5%, 1999-2000 онуудад өсөлттэй буюу 8.7-13.2% өсөлттэй байсан бол 2001 онд уналтад орж -6.9% байсан бол 2002 онд 4.6%, 2003 онд 0.5% байсан бол өсөөд 2003 онд 6.6%-д хүрсэн байна.

Зочид буудал, зоогийн газар болон бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухайн салбарын үйлдвэрллийн хэмжээнд үзүүлэх мэдрэмжийг 1995-2004 оны тоон мэдээлэл дээр тооцоход 0.29 гарч байгаа бөгөөд эндээс харахад тухайн салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт өсөхөд тухайн салбаруудын үйлдвэрлэл өсдөг байна. Тухайн салбаруудын хувьд 1999-2000 онуудад жил бүр хөрөнгө оруулалт ойролцоо байсан бөгөөд энэ үед салбарын өсөлт мөн байсан байсан, тус салбарт 2002 онд хамгийн өндөр хөрөнгө оруулалт орон гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд олноор байгуулагдахад эдийн засгийн өсөлт нь мөн өссөн зэргээс харахад тухайн салбарын онлогоос харахад тус салбар дахь хөрөнгө оруулалтын нөлөө 1 жилдээ багтан салбарын улмаар нийт эдийн засгийн үйлдвэрлэл, өсөлтөд нөлөөлдөг байна. Харин одоо гадаадын хөрөнгө оруулалтаар хичнээн компаниуд байгуулагддаг, тэдгээрийн орон нутаг дахь тархалтыг 3.1.3 хэсэгт авч үзсэн дээрээ үндэслэн гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын төсөвт төлөх татварын орлого, орон нутагт ажлын

байр нэмэгдүүлэх гэх мэт байдлаар эдийн засгийн хөгжилд нөлөөтэй байж болох боломжийг авч үзье.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг орон нутгийн байршлаар авч үзэхэд Улаабаатар хотод хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэн нь ордог бол аймагуудын хувьд Орхон аймаг, Дорнод аймаг, Дархан уул аймаг, Өмнөговь аймаг, Төв аймгуудад бусад аймгийг бодвол томоохон хэмжээний шууд хөрөнгө оруулалт, харин үлдсэн аймгуудад өчүүхэн бага хэсэг нь ордог байна. Энэ утгаараа гадаадын шууд хөрөнгө оруулалтаар байгуулагдаж байгаа компанийн тоог орон нутгийн байршлаар авч үзэхэд мөн л хөрөнгө оруулалтын хэмжээтэй адил үр дүн харуулж байгаа юм.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, шууд хөрөнгө оруулалттай компаниуд байгуулагдах нь зөвхөн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ, өсөлтийг нэмэгдүүлэхээс гадна тухайн бүс, орон нутагт үйл ажиллагаа явуулах болсноор дэд бүтцийн зам, тээвэр, харилцаа холбоо, барилга байгууламж, цахилгаан гэх мэт дэд бүтцийн салбарууд сайжрах бөгөөд мөн орон нутгаас авч ашиглах ажлын байр нэмэгдэж, иргэдийн амьжиргааны түвшин дээшлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хэмжээ нэмэгдэн нэгдсэн болон орон нутгийн төсөвт төлөх татварын орлого өсөх зэрэг эдийн засгийн нөлөө мөн дэлхий дээр шинээр нэвтэрч буй технологийн дэвшил цаг алдахгүй орж ирэх чухал эерэг дам нөлөөнүүдийг бий болгоно.

Манай орны хувьд энэ нөлөөлөл Улаанбаатар хотын хувьд бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар, зочид буудал, зоогийн газрын гэх мэт ерөнхийдөө үйлчилгээний салбарт илүүтэй ажиглагдаж байгаа бөгөөд мөн харилцаа холбоо, мэдээлэл технологи, барилга, цахилгаан эрчим хүчний салбарт эерэг дам нөлөөнүүдийг илүүтэй үзүүлж байна. Тэгвэл аймгуудын хувь дахь хөрөнгө оруулалт нь голлон уул, уурхай олборлох үйлдвэрийн салбарт голлох бөгөөд бусад аймгуудыг бодвол Орхон аймаг, Дорнод аймаг, Дархан уул аймаг, Өмнөговь аймаг, Төв аймгуудад газрын хэвлийн нөөц, орд газар зэрэг геологийн баялаг сайтайгаас эдгээр аймгуудад дээрх эерэг нөлөөллүүд ажиглагдаж байна.

### **3.3 ГШХО болон ДНБ-ний хамаарлын эконометрик загварын үнэлгээ<sup>16</sup>**

Энэ хэсэгт онолын хэсгийн 2.3-д үзүүлсэн ГШХО болон ДНБ-ний хоорондын хамаарлыг харуулсан аль нь алиныхаа Гранжер шалтгаан болдог, урт хугацаанд ГШХО-ын өсөлт ДНБ-нийг хэдэн хувиар өсгөж байгааг эконометрик үнэлгээгээр шалгах юм. Ийнхүү судлахдаа загварт тодорхойлогдсон ёсоор panel өгөгдлийг ашиглалаа. Panel өгөгдлийг үүсгэхдээ манай оронтой адилаар шилжилтийн эдийн засагтай тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд (ТУХНО)-аас манай оронтой нэг хүнд ногдох ДНБ болон ГШХО, ДНБ-ний харьцаа ойролцоо байхыг суурь болгон Азербайжан, Гүрж, Казахстан, Молдав, Таджикстан, Армен болон Монгол гэсэн нийт 7 улсын 1994-2004 онуудын тоон мэдээллээр үүсгэсэн.<sup>17</sup> Panel өгөгдөлтэй ажиллаж байгаа тул хувьсагчдын тогтвортой эсэхийг шалгаж, тогтворгүй үзүүлэлтүүд байвал тэдгээрийн хооронд коинтегрэшин хамаарал байгаа эсэхийг шалгах ёстой болно.

<sup>16</sup> Өгөдлийн шинж чанарын тестүүд, эконометрик үнэлгээ, хамаарлын тестүүдийн Eviews 5.0 програм дээр хийсэн болно. Үнэлгээний аргын сонголтын хувьд panel өгөгдлийн үнэлгээнд гарч болох алдаануудыг засварлах хамгийн боломжит аргуудаар үнэлж эдийн засгийн онолын хувьд нийцтэй, статистик шинжүүр ач холбогдолтойг сонгосон болно. Хүснэгт 9-д байгаа систем тэгшитгэлийн үнэлгээг орнуудын хувьд болон цаг хугацааны хувьд fixed effect-тэй, жингийн хувьд улсуудаар нь жигнэсэн буюу cross-section weights, коэффициентийн ковариацийн хувьд түүвэрлэсэн орнуудын хувьдын шинж чанартай алдаа үүсэх тул cross-section SUR (PCSE) гэсэн panel тохиргоо хийн үнэлсэн болно.

<sup>17</sup> Panel өгөгдлийг 1990 оноос хойших байдлаар авч болох хэдий ч тухайн орнуудын хувьд 1990 оноос эдийн засгийн бүтцийн өөрчлөлт орсон шилжилт эхэлсэн орнууд тул үүний нөлөөг багасгах үүднээс 1994 оноос хойших өгөгдлийг ашиглалаа.

### 3.3.1 Time series шинж чанар

ГШХО болон ДНБ-ний хооронд Гранжер шалтгаан байгаа эсэхийг шалгахын өмнө эдгээр үзүүлэлтүүдийн Time series шинж чанарыг судлах хэрэгтэй болно. Panel өгөдлийг ашиглаж байгаа тул ерөнхийдөө тухайн үзүүлэлт тогтвортой эсэхийг нэгж язгуурын panel тестүүдээр шалгаж хүснэгт 7-д харууллаа.

#### Хүснэгт 7. Panel өгөдлийн нэгж язгуурын тест

Арга Үзүүлэлтүүд	Энгийн (Level)**		I эрэмбийн ялгавар***	
	Log(GDP)	FDI/GDP	dLog(GDP)	d(FDI/GDP)
<b>H<sub>0</sub>: нэгж язгууртай (common)</b>				
Levin, Li & Chu t	-7.64	-1.33	-8.74	-5.91
H <sub>0</sub> үнэн байх магадлал*	[0.000]	[0.092]	[0.000]	[0.000]
Breitung t-stat	2.02	-0.97	-6.04	-3.80
H <sub>0</sub> үнэн байх магадлал*	[0.978]	[0.167]	[0.000]	[0.000]
<b>H<sub>0</sub>: нэгж язгууртай (individual)</b>				
Pesaran and Shin W-stat	-1.92	0.56	-	-
H <sub>0</sub> үнэн байх магадлал*	[0.027]	[0.714]	-	-
ADF-Fisher Chi-square	35.33	13.45	79.56	55.52
H <sub>0</sub> үнэн байх магадлал*	[0.001]	[0.491]	[0.000]	[0.000]
PP-Fisher Chi-square	45.54	10.33	93.51	70.07
H <sub>0</sub> үнэн байх магадлал*	[0.000]	[0.738]	[0.000]	[0.000]
<b>H<sub>0</sub>: нэгж язгуургүй (common)</b>				
Hadri Z-stat	3.63	3.21	-	-
H <sub>0</sub> үнэн байх магадлал*	[0.000]	[0.001]	-	-
Тогтвортой эсэх	Тогтворгүй	Тогтворгүй	Тогтвортой	Тогтвортой

- \*- Fisher-ийн тестүүдийн бүх магадлалуудыг асимптотик  $\chi^2$  тархалтын ашиглан тооцоолсон. Бусад бүх тестүүдийг асимптотик нормаль тархалттай гэж таамагласан.
- \*\* - Энгийн (level) хэлбэрт өгөдлийн нэгж язгуурыг шалгахдаа тэгшитгэлийн хэлбэрийг хувийн нөлөө (сул гишүүн) болон трендийг хамт оруулан үнэлсэн. Мөн эдгээр үзүүлэлтүүдийн оновчтой лагууд нь SIC шинжүүрээр 0-ээс 1 байсан.
- \*\*\* - I эрэмбийн ялгаварын дараах өгөдлийн нэгж язгуурыг шалгахдаа тэгшитгэлийн хэлбэрийг хувийн нөлөө (сул гишүүн) болон тренд агуулагүй (none) хэлбэрт үнэлсэн. Мөн эдгээр үзүүлэлтүүдийн оновчтой лагууд нь SIC шинжүүрээр 0-ээс 1 байсан болно.

Хүснэгт 7-оос харахад ДНБ-ний логарифм болон ГШХО-ын ДНБ-нд эзлэх хувь гэсэн хувьсагч бүрийг нэгж язгууртай гэсэн тэг таамаглал тавин шалгахад энгийн (level) түвшинд тухайн таамаглалыг няцаахгүй байгаа бөгөөд харин нэгдүгээр эрэмбийн ялгаврын дараа тус таамаглалыг няцааж байна. Эндээс бид эдгээр үзүүлэлтүүд нь ялгаварын дараа тогтвортой буюу дундажынхаа орчимд тогтвортой байна. Иймд тухайн үзүүлэлт нь энгийн (level) түвшинд тогтворгүй байгаа тул эдгээр үзүүлэлтүүдийн хувьд коинтегрэйн хамаарал байгаа эсэхийг Johansen коинтегрэйн тестээр шалгаж хүснэгт 8-д үзүүлээ.

#### Хүснэгт 8. Panel өгөдлийн хязгаарлалт тавигдаагүй коинтегрэйн урт хугацааны хамаарлын ранк тест (Johansen тест), 7 орны 1994-2004 оны жилийн өгөгдөл

Log(GDP)=F(FDI/GDP) хамаарлын коинтегрэйн тест		
H <sub>0</sub> таамаглал	r=0	r=1
Эйгэн утга	0.166	0.095
Трэйс статистик	15.69*	5.56*
5 %-ийн критик утга	(12.32)	(4.13)
Магадлал	[0.013]	[0.022]
Мак-Эйгэн статистик	10.14	5.56*
5 %-ийн критик утга	(11.22)	(4.13)

- \*- тэмдэг нь 5%-ийн ач холбогдлын түвшинд ко-интэгрэйн хамаарал байхгүй гэсэн  $H_0$  таамаглалыг няцааж байгаа үзүүлнэ. Өөрөөр хэлбэл трэйс тест нь 5%-ийн ач холбогдлын түвшинд 2 коинтэгрэйн тэгшитгэл байж болохыг үзүүлж байна.
- Коинтэгрэйн векторуудыг өгөгдөлд детерминистик тренд байхгүй гэж таамаглал доор шалгасан. Магадлалын хувьд MacKinnon-\*Haung-Michelis (1999) p-утга болно.

Хүснэгт 8-аас харахад  $[\log(GDP_{it}), FDI_{it}/GDP_{it}]$  загварын хувьд трэйс тест нь 5 %-ийн ач холбогдлын түвшинд 2 боломжит коинтэгрэйн хамаарал (тэгшитгэл) байгааг харуулж байна. Эдгээрээс харахад хувьсагчид нь тогтворгүй боловч урт хугацааны коинтэгрэйн хамааралтай, харин ялгаврын дараа тогтвортой гэсэн үр дүн өгсөн тул бид шууд (1) хэлбэрийн VAR загварыг үнэлж болохгүй харин түүний алдааг залруулах (error-correction) хэлбэрт оруулсан (4)-т тодорхойлогдсон тэгшитгэлийн системийг үнэлж аль нь алины Гранжер шалтгаан болж байгааг (5) таамаглалыг шалгах байдлаар тодорхойлж, урт хугацааны нөлөөллийн параметрыг (7) матрицыг тооцох байдлаар олох болно.

### 3.3.2 $\log(GDP_{it}), FDI_{it}/GDP_{it}$ хоорондын Гранжер шалтгаан

Хүснэгт 9-д онолын загварын (4)-т тодорхойлогдсон тэгшитгэлийн системийг тогтмол нөлөөний (fixed effect) аргаар үнэлсэн үнэлгээний үр дүн болон  $\log(GDP_{it}), FDI_{it}/GDP_{it}$  хоорондын Гранжер шалтгааны тестийн үр дүнг харууллаа.

#### Хүснэгт 9. Log(GDP) болон FDI/GDP системийн дан тэгшитгэлүүдийн үнэлгээ

Арга	Тогтмол нөлөөний (fixed effects) үнэлгээ	
Тэгшитгэл Хамаарах хувьсагч	(1a) dlog(GDP)	(1b) d(FDI/GDP)
dlog(GDP)(t-1)	-0.187	-0.019
t-стат	[2.58]	[0.61]
d(FDI/GDP)(t-1)	-0.719	0.669
t-стат	[4.17]	[4.19]
log(GDP)(t-1)	-0.331	-0.019
t-стат	[4.68]	[0.49]
(FDI/GDP)(t-1)	0.523	-0.814
t-стат	[3.05]	[4.82]
Granger causality ( $H_0$ үнэн байх магадлал)	0.0003	0.6323
Neutrality ( $H_0$ үнэн байх магадлал)	0.0035	0.6284

- Granger causality-г шалгахдаа wald тестийг ашигласан бөгөөд FDI/GDP нь log(GDP)-ийн шалтгаан болж байгаа эсэхийг шалгахдаа  $H_0: c(1)=c(4)=0$ , харин log(GDP) нь FDI/GDP-ийн шалтгаан болж байгаа эсэхийг шалгахдаа  $H_0: c(2)=c(3)=0$  гэж шалгасан болно.
- Харин Neutrality -г буюу урт хугацааны нөлөө байгаа эсэхийг шалгахдаа wald тестийг мөн ашигласан бөгөөд FDI/GDP нь log(GDP)-ийн шалтгаан болж байгаа эсэхийг шалгахдаа  $H_0: c(4)=0$ , харин log(GDP) нь FDI/GDP-ийн шалтгаан болж байгаа эсэхийг шалгахдаа  $H_0: c(3)=0$  гэж шалгасан болно.

Хүснэгт 9-ээс харахад  $\log(GDP_{it}), FDI_{it}/GDP_{it}$  системийн харилцан шалтгааныг 5 %-ийн түвшинд шалгахад статистикийн хувьд FDI/GDP харьцаа нь ДНБ-ний шалтгаан болж байгааг хангалттай түвшинд илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл ГШХО-аас ДНБ-ний өсөлт рүү чиглэлтэй буюу ГШХО өсөх нь ДНБ-нийг өсгөх шалтгаан болж байгааг харуулж байна. Харин эсрэг чиглэлд нөлөө байдаггүй болохыг статистикийн хувьд нотолж байна.

Мөн урт хугацаанд нөлөөтэй эсэх (neutrality)-ийн тестийг шалгахад мөн урт хугацаанд FDI/GDP харьцаа нь ДНБ-ний шалтгаан болж байгааг хангалттай түвшинд нотолж байгаа бөгөөд харин эсрэг чиглэлд огт нөлөөлөгүй болохыг статистик тестийн үр дүн

харуулж байна. Өөрөөр хэлбэл,  $\log(GDP_{it}), FDI_{it}/GDP_{it}$  системийн

$\log(GDP)=F(FDI/GDP)$  хамаарлын хувьд урт хугацаанд ГШХО нь эдийн засгийн өсөлтөд нөлөөтэй буюу C матрицын эерэг диагональ матрицууд нь тэгээс ялгаатай гэсэн үр дүн харуулж байна. Иймд тухайн матрицын  $\hat{c}_{12}$  элемент нь урт хугацаанд ГШХО нэг хувь өсөхөд ДНБ-ний өсөлт хэдэн хувиар өсөхийг илэрхийлэх тул үүнийг тооцоход 1.89 байна. Азербайжан, Гүрж, Казахстан, Молдав, Тажикстан, Армен болон манай орны хувьд адилхан шилжилтийн хөгжиж буй эдийн засагтай, нэг хүнд ногдох ДНБ болон ГШХО, ДНБ-ний харьцаа нь ойрхон тул энэхүү коэффициент нь эдгээр улсуудын хувьд урт хугацааны хамаарлыг илэрхийлж чадна гэж үзнэ. Иймд манай орны хувьд ГШХО болон ДНБ-ний харьцаа 1 хувь өсөх нь урт хугацаанд ДНБ-ийг 1.87 хувиар өсгөхийг илтгэж байна.

